

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК

2012 оны 3 дугаар сар



Улаанбаатар Цэвэр Агаар сан – II үе
Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн
судалгаа
Огноо: 2012 оны 3 дугаар сар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЕСБХБ

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл:

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
1	29/02/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет Де Вилдт Онно Ван Ден Хийвел Суззане Рулофс		
2	6/03/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет Де Вилдт Онно Ван Ден Хийвел		
3	17/03/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет Де Вилдт	Каролинэ Ла Чапел	Тайлан батлагдсан

УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР САНААЧЛАГА II

Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд хоол хүнс бэлтгэх, гэр сууцаа халаахдаа хэрэглэж байгаа зуух нь бүтээмж бага, мөн түлшний зориулалтаар ашиглаж буй нүүрсний чанар муу тул өвлийн улиралд агаарын бохирдлыг үүсгэдэг гол хүчин зүйл болж байна. Улаанбаатар хотын агаарын чанарын түвшин жилээс жилд буурч, хотын хүн амын эрүүл мэнд, улс орны эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх хандлага нэгэнт бий болжээ. Гэр хорооллын айлуудын ашиглаж буй зуухны загварыг сайжруулж, түүхий нүүрсийг шууд хэрэглэж байгааг шигшиж цэвэршүүлсэн, утаа ялгаруулалт багатай, үр ашигтай түлшээр солих нь Улаанбаатар хотыг хамарсан агаарын бохирдлын асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арга зам, гарц болоод байна. 2008 оноос эхлэн Улаанбаатар хотын удирдлагууд түүхий нүүрс түлшэнд хэрэглэхийг хориглосон ч цэвэр түлшний хангамж хязгаарлагдмал, өртөг өндөр, мөн тухайн харилцааг зохицуулах хууль, эрхзүйн орчин тодорхой бус байсны улмаас тус хориг нь төдийлэн биелэлээ олоогүй юм. Олон улсын санхүүгийн байгууллагууд (цаашид “ОУСБ-ууд” гэх), хөгжлийн агентлагууд, хандивлагч байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын (цаашид “Засгийн газар” гэх) хүсэлтээр агаарын бохирдолд нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банк нь зуухыг шинэчлэн солих хөтөлбөрийг боловсруулахаар тохиролцсон бөгөөд Засгийн газрын зүгээс Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкинд (цаашид “ЕСБХБ” эсвэл “Банк” гэх) түлшийг шинэчлэн солих ажлын тодорхой хэсэгт тусламж үзүүлэх хүсэлт тавьсан. ЕСБХБ нь 2008 оны 09 дүгээр сараас түүхий нүүрсний хэрэглээг цэвэр, хор багатай түлшээр солих төлөвлөгөөг боловсруулахаар Засгийн газартай хамтран ажиллаж эхэлсэн юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд 2009 оны 06 дугаар сард Засгийн газарт өргөн мэдүүлсэн Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөнд (“Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө” гэх) тусгагдсан юм. Энэхүү төслийн 1 дүгээр үе шатны үр дүнгийн нэг хэсэг нь Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө нь түлшийг шинэчлэн, солихтой холбоотой, өөр хоорондоо харилцан уялдаа бүхий олон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн цогц арга, аргачлалаас бүрдэнэ. 2010 оны 06 дугаар сард Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг Засгийн газар, Агаарын тухай багц хуулийг Монгол Улсын Парламентаар батласны дараа Банк төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү бичиг баримт нь Засгийн газарт Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх Зөвлөх мэргэжилтнүүдэд зориулсан ажлын удирдамж болно.

Агуулга

Оршил.....	5
1 Тайлангийн хураангуй	6
2 Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалт.....	7
2.1 Цэвэр агаарын сан үүсгэн байгуулагдсан эрх зүйн үндэслэл.....	7
2.2 Цэвэр агаарын сангийн удирдлага бүтэц, зохион байгуулалт.....	7
2.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд удирдах зөвлөлийн дарга.....	7
2.2.2 Удирдах зөвлөл.....	11
2.2.3 Удирдах зөвлөлийн эрх зүйн зохицуулалт:	11
2.2.4 Удирдах зөвлөлийн бүрэн эрх:	12
2.2.5 Гүйцэтгэх захирал.....	14
2.2.6 Цэвэр агаарын сангийн ажлын алба.....	16
3 Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах тайлагнах, хяналт тавих.....	19
3.1 Санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.....	19
3.2 Цэвэр агаарын сангийн эх үүсвэр.....	19
3.3 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах.....	19
3.3.1 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах, тайлагнах.....	20
3.3.2 Цэвэр агаарын сангийн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөх, тайлагнах.....	21
3.3.3 Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт.....	21
3.4 Судалгааны товч санал, дүгнэлт.....	25
3.4.1 Цэвэр агаарын сангийн эх үүсвэрийн талаар.....	25
3.4.2 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах талаар:.....	25
3.4.3 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах, тайлагнах талаар:	26
3.4.4 Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаар:	26
3.5 Цэвэр агаарын сан бусад байгууллагатай харилцах.....	27
3.5.1 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо.....	27
3.5.2 Нийслэлийн Агаарын чанарын алба.....	30
3.6 Аж, ахуйн нэгжтэй харилцах.....	35
3.6.1 Аж ахуйн нэгж, байгууллагын эрх зүйн зохицуулалт.....	35
3.6.2 Аж ахуйн нэгжийн бүрэн эрх.....	35
4 Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох.....	36

4.1	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, хариуцлага.....	36
4.1.1	Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:.....	37
4.1.2	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа дуусгавар болох:.....	38
4.1.3	Судалгааны товч дүгнэлт, санал:.....	39
5	Цэвэр агаарын сангийн холбогдох дүрэм журамд хийсэн судалгаа.....	41
5.1	Бүлгийн талаар товч танилцуулга.....	41
5.2	Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн ажиллах журам”-д хийсэн судалгаа.....	41
5.2.1	Журмыг батлах эрх зүйн үндэслэл.....	41
5.2.2	Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:.....	42
5.3	Цэвэр агаарын сангийн дүрэмд хийсэн судалгаа.....	43
5.3.1	Дүрэм батлах эрх зүйн үндэслэл.....	43
5.3.2	Дүрэмд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:.....	44
5.4	“Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д хийсэн судалгаа.....	44
5.4.1	Журам батлах эрх зүйн үндэслэл.....	44
5.4.2	Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:.....	45
5.5	Цэвэр агаарын сангийн “Хөдөлмөрийн дотоод журам”- д хийсэн судалгаа.....	46
5.5.1	Журмыг батлах эрх зүйн үндэслэл.....	46
5.5.2	Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:.....	48

Товчилсон үгийн жагсаалт:

ЦЭВЭР АГААРЫН САН	Цэвэр агаарын сан
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТБОНОХБАҮХАТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
НАЧА	Нийслэлийн Агаарын чанарын алба
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар

Оршил

Улаанбаатар хотын Цэвэр агаар санаачлага II төслийн ажлын удирдамжийн 3 дугаар зүйлийн 3.4.1 дэх хэсэгт заасан “**Цэвэр агаарын сангийн тухай ойлголт, холбогдох хууль, дүрэм, журмыг удирдах зөвлөлд тайлбарлан танилцуулах болон тэдгээрт дүгнэлт, зөвлөмж боловсруулах**” зорилгоор уг судалгааны тайланг бэлтгэлээ.

Уг судалгааг нийт Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хүчин төгөлдөр хууль тогтоомжийн¹ хүрээнд хийв.

Судалгааны зорилго, хүлээгдэж байгаа үр дүнтэй уялдуулж дараах аргыг ашигласан болно.

- Ярилцлагын арга
- Баримт бичгийн шинжилгээ
- Харьцуулалтын арга /*бичвэр харьцуулах*/
- Задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх.

Судалгааны мэдээллийг ганцаарчилсан ярилцлагын аргаас гадна бичиг баримтад дүн шинжилгээ хийх аргачлалаар цуглуулав.

Судалгаанд энэ талаар манай улсад урьд хийгдэж байсан судалгааны ажил, түүний тайлан, нийтлэл, илтгэл, бусад баримт бичиг, одоо мөрдөж буй холбогдох хууль тогтоомж, ЗГ-ын тогтоол, яам, агентлагийн хэм хэмжээний акт, түүнчлэн судалгаагаар цуглуулсан бусад мэдээлэл зэрэг өргөн хэмжээний материал ашигласан болно.²

¹ Тус тайлангийн хуудсанд тусгасан.

² Ашигласан материалын жагсаалтыг тайлангийн 48-50 хуудаснаас харна уу.

1 Тайлангийн хураангуй

Цэвэр агаарын сангийн үүсгэн байгуулагдсан хууль зүйн үндэслэл, удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, түүнд тавигдах хяналт, бусад байгууллагатай харилцах хэлбэр зэрэг нөхцөл байдлуудыг судлаж, тус сангийн эрх зүйн орчинг тодорхойлоход энэхүү бүлгийн гол зорилго оршиж байгаа болно.

Энэхүү судалгааны хүрээнд **Цэвэр агаарын сангийн** ерөнхий ойлголтыг тодорхойлохдоо одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд эдгээр хууль тогтоомжоос **Цэвэр агаарын сангийн** үйл ажиллагааг зохицуулж буй тодорхой зүйл заалтуудыг түүвэрлэн, нэгтгэж ойлгомжтой байдлаар томъёолсон юм.

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хүчин төгөлдөр хууль тогоомжууд гэдэгт Агаарын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, болон тус сантай холбогдон гарсан дүрэм журмуудыг хамруулсан болно.

Мөн судалгаагаар Цэвэр агаарын сангий үйл ажиллагааг зохицуулж буй үндсэн дүрэм журмууд болох Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн ажиллах журам”, “Цэвэр агаарын сангий дүрэм”, “Цэвэр агаарын сангийн бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”, Цэвэр агаарын сангийн “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг дүрэм, журмуудад эрх зүйн судагаа хийсэн болно.

Судалгаагаар дээрх дүрэм, журмууд батлагдан гарах эрх зүйн үндэслэлийг судалж дүгнэлт өгсөн бөгөөд дүрэм журмын тодорхойгүй, зөрчилтэй, хууль нийцээгүй, заалт тус бүр дээр тайлбар өгч, гарц болох сөрөг үр дагаврыг тодорхойлон хэрхэн засаж болох талаар төсөл гүйцэтгэгчийн зүгээс судалгаанд оруулсан юм. Мөн судалгаанд хамрагдсан дүрэм журмуудад нэмж зохицуулах шаардлагатай гэж үзсэн зүйлүүдийг санал болгон оруулсан.

Энэхүү судалгаа нь Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалтын суурь судалгаа бөгөөд энэхүү судалгаанд үндэслэн тус сангийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм журмыг боловсронгуй болгож ажил үргэлжлэн явах болно.

2 Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалт


2.1 Цэвэр агаарын сан үүсгэн байгуулагдсан эрх зүйн үндэслэл

2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлд Цэвэр агаарын сангийн талаарх зохицуулалт орсон бөгөөд энэхүү Агаарын тухай хуулийн заалтыг үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль³д 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.29-д Цэвэр агаарын санг тусгай сангийн төрөлд оруулан хуульчилсан юм.

Улмаар 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 273 тоот Засгийн газрын тогтоолоор “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан байна.

Ийнхүү Цэвэр агаарын сан нь агаарыг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагаанд зориулан уг сангаас санхүүжүүлсэн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулах зорилготойгоор⁴ үүсгэн байгуулагдах эрх зүйн үндэслэл бий болсон байна.

2.2 Цэвэр агаарын сангийн удирдлага бүтэц, зохион байгуулалт



2.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд удирдах зөвлөлийн дарга

Агаарын тухай Монгол Улсын хуулиар Цэвэр агаар сангийн үйл ажиллагааг үндсэнд зохицуулдаг. Түүнчлэн холбогдох бусад хуулийн хүрээнд Цэвэр агаар сан нь Удирдах Зөвлөл (“Удирдах Зөвлөл”) бөгөөд энэ нь цг сангийн үйл ажиллагааг нь удирдлагаар хангадаг. Тэрхүү Удирдах Зөвлөлийн дарга нь Цэвэр агаар сангийн үйл ажиллагааг нь үндсэнд нь удирдлагаар хангахаас гадна Төсвийн удирдлага санхүүжилтийн тухай

³ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006 оны 6 сарын 29 өдөр батлагдсан. /6 бүлэг, 33 зүйлтэй./

⁴ Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан Цэвэр агаарын сангийн дүрэм

хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх эрх, үүрэг бүхий албан тушаалтан юм.

2.2.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд зөвлөлийн даргыг томилох:

Цэвэр агаарын сангийн Төсвийн Ерөнхийлөн захирагч⁵ бөгөөд Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн дарга⁶ нь Байгаль орчин аялал жуучлалын сайд байхаар шууд тодорхойлон хуульчилсан байна.

Иймээс Төсвийн Ерөнхийлөн захирагчийг томилох асуудал байхгүй бөгөөд Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.-д “Цэвэр агаарын сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна” гэж хуульчилсан тул Байгаль орчин аялал жуучлалын сайд уг сангийн төсвийн ерөнхийлөн захирагч болж байгаа юм.

Мөн Цэвэр агаарын сан нь үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлтэй бөгөөд уг удирдах зөвлөлийн даргыг Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2. “Зөвлөлийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орлогч дарга нь Сангийн дэд сайд, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан нэгжийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд орлогч дарга зөвлөлийг удирдана” гэж шууд заасан байх тул мөн Байгаль орчин аялал, жуучлалын сайд албан тушаалаар зөвлөлийн дарга болж байна. Иймээс хууль болон журмаар албан тушаалыг шууд тодорхойлон заасан байх тул Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд удирдах зөвлөлийн даргыг томилох асуудал байхгүй байна.

2.2.1.2 Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд зөвлөлийн даргыг чөлөөлөх:

Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд зөвлөлийн дарга нь хууль болон журамд албан тушаалаар шууд заагдсан тул байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Байгаль орчин аялал, жуучлалын сайдыг чөлөөлөх асуудал гарч ирэх юм. Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д зааснаар Засгийн газрын бүрэлдэхүүнийг өөрчлөх, гишүүнийг томилж чөлөөлөх асуудлыг Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг байна.

Түүнээс зөвхөн Цэвэр агаарын сангийн төсвийн ерөнхийлөн захирагч болон зөвлөлийн даргын хувьд чөлөөлөх асуудлыг тусгайлан заасан зохицуулалт байхгүй бөгөөд ийм зохицуулалт байх үндэслэл байхгүй байгаа юм.

⁵ Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.-д “Цэвэр агаарын сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна”

⁶ Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2 “Зөвлөлийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орлогч дарга нь Сангийн дэд сайд, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан нэгжийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд орлогч дарга зөвлөлийг удирдана”

2.2.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд зөвлөлийн даргын эрх зүйн зохицуулалт:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрх үүргийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд Удирдах зөвлөлийн даргын эрх үүргийг Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн даргын эрх үүргийг Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар тус тус зохицуулж байна.

2.2.1.4 Төсвийн Ерөнхийлөн захирагч болон зөвлөлийн даргын эрх, үүрэг:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд:

- Эрхлэх асуудлынхаа хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого санхүүжилтийн хэрэгцээгээ бодитой тодорхойлох.
- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэлийг хангуулах.
- Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд мэдээлэл өгөх.
- Дэвшүүлсэн хэтийн зорилтоо хэрэгжүүлэхэд төрийн зохицуулалт шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад санал оруулах.
- Эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах.
- Эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах.
- Эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний нийлүүлэлт, санхүүгийн үр дүнг хянаж дүгнэх.⁷

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн даргын хувьд:

- Орон тооны бус зөвлөлийн гишүүдийг Ерөнхий сайдад санал болгох.
- Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлыг Зөвлөлийн санал болгосноор томилж чөлөөлөх.
- Гүйцэтгэх захиралтай үр дүнгийн гэрээ байгуулах⁸ зэрэг эрхтэй болно.

Мөн дараах бусад эрхийг эдэлнэ:

⁷ Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 11 дүгээр зүйл.

⁸ Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”

- Цэвэр агаарын сангийн дүрэм.
- Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам.
- Цэвэр агаарын сангийн стратеги бүтэц зохион байгуулалтын хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийг баталсан байна.

Эдгээр эрхүүд нь ямар нэгэн хууль журамд тусгагдаагүй хэдий ч одоогоор дээрх баримт бичгүүдийг Байгаль орчин аялал жуучлалын сайд батлаад байгаа юм⁹.

2.2.1.5 Судалгааны товч дүгнэлт, санал

Байгаль орчин аялал, жуучлалын сайд нь Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд зөвлөлийн дарга болж байна.

Энэхүү албан тушаалууд нь хууль зүйн хувьд тус тусдаа зохицуулагдах хэм, хэмжээтэй бөгөөд эрх, үүрэгтэй юм. Гэтэл Байгаль орчин, аялал жуучлалын яамны сайд нь “Цэвэр агаарын сангийн дүрэм, Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам”, Цэвэр агаарын сангийн стратеги бүтэц зохион байгуулалтын төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг баталж байгаа бөгөөд эдгээр баримт бичгүүдийг ямар эрх хэмжээний хүрээнд баталсан болох нь ойлгомжгүй байна.

Уг Байгаль орчин аялал, жуучлалын сайдын тушаал нь “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.4.29¹⁰, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2¹¹, “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7. зэргийг үндэслэл болгожээ. Эдгээр үндэслэл болгож буй хууль, журамд “Цэвэр агаарын сангийн дүрэм, Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам” батлах эрх олгосон талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй.

Иймээс Цэвэр агаарын сангийн дүрэм, Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам, зэрэг баримт бичгийн ямар хууль, ямар эрх бүхий этгээд батлах нөхцөл байдал нь ойлгомжгүй байна.

Байгаль орчин аялал, жуучлалын сайд нь “Цэвэр агаарын сангийн хувьд Төсвийн ерөнхийлөн захирагч, мөн Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын

⁹ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан

¹⁰ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн “Цэвэр агаарын сан”

¹¹ Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д

“Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

Хэрэв эрхэлсэн асуудлынхаа хүрээнд шийдвэрлэх гэж байгаа асуудал нь бусад хүрээнийхтэй шууд холбоотой бол Засгийн газрын холбогдох гишүүдтэй урьдчилан тохиролцож зохицуулсан байвал зохино. Засгийн газрын гишүүд удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар хамтарсан тушаал гаргаж болно. Энэ талаар гарсан саналын зөрөөг өөрсдөө зохицуулж чадаагүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээний үндсэн дээр шийдвэрлэнэ.”

оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд ийнхүү тухайн албан тушаал бүр нь өөр өөр эрх зүйн зохицуулалтаар зохицуулагдаж байна. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг тодорхойгүй байх бөгөөд Цэвэр агаарын сангийн удирдлагын эрх үүргийг нэгтгэн тодорхойлсон нэг баримт бичиг шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал:

- 1) Цэвэр агаарын сангийн дүрмийг батлах эрх бүхий этгээдийг тодорхой болгох шаардлагатай байна. Цэвэр агаарын сангийн удирдлага нь Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөл байх бөгөөд тус сангийн дүрэм, болон Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журмыг тус зөвлөлөөр батлуулах эрхийг тодорхойлж өгөх нь тохиромжтой гэж үзэж байна. Учир нь тус зөвлөлийн дарга нь дангаараа Цэвэр агаарын сангийн дүрмийг батлаж байгаа нөхцөл байдал одоо бий болоод байна.
- 2) Байгаль орчин аялал, жуучлалын сайд нь Цэвэр агаарын санг удирдах эрх үүргийг тодорхойлсон нэгдсэн баримт бичиг шаардлагатай байгаа болно.

2.2.2 Удирдах зөвлөл

2.2.2.1 Удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх:

Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2. “Зөвлөлийн дарга нь байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрийн гишүүн, орлогч дарга нь Сангийн дэд сайд, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан нэгжийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд орлогч дарга зөвлөлийг удирдана” гэж заасны дагуу Зөвлөлийн дарга болон орлогч дарга нь албан тушаалаар шууд удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд багтаж байна.

Зөвлөл нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд бусад гишүүдийг зөвлөлийн даргын санал болгосноор Ерөнхий сайд томилж чөлөөлөхөөр зохицуулсан байдаг.¹²

Дээр дурьдсан зөвлөлийн дарга болон орлогч даргаас бусад зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага болон албан тушаалыг тодорхой зааж зохицуулаагүй тул Зөвлөлийн дарга өөрийн эрхийн хүрээнд ямар ч этгээдийг санал болгох боломжтой байгаа юм.

Мөн чөлөөлөх асуудлыг Зөвлөлийн дарга Ерөнхий сайдад санал болгох бөгөөд ямар үндэслэлээр чөлөөлөх, чөлөөлөх журам зэргийг зохицуулаагүй тул мөн Зөвлөлийн дарга өөрийн үзэмжээр чөлөөлөх саналыг Ерөнхий сайдад оруулах боломжтой.

2.2.3 Удирдах зөвлөлийн эрх зүйн зохицуулалт:

¹² Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3 дугаар заалт

Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.-д “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газар 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 273 тоот Засгийн газрын тогтоолоор “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан байна.

Энэхүү журам нь удирдах зөвлөлийн ажиллах журмыг зохицуулсан үндсэн баримт бичиг болж байгаа юм. Харин Агаарын тухай болон Засгийн газрын тусгай сангийн тухай мөн бусад холбогдох хуулиудад Засгийн газрын тусгай сангийн удирдах зөвлөлийн ажиллах журам, эрх үүргийн талаар ямар нэгэн нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа юм.

Мөн “Цэвэр агаарын сангийн дүрэм”¹³ болон “Цэвэр агаарын санг бүрдүүлэх захиран зарцуулах түүнд хяналт тавих журам”¹⁴ зэрэгт Удирдах зөвлөлийн зарим эрх үүргийг тодорхойлж өгсөн байна.

Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нийт гишүүдийн хурал байх бөгөөд хурлыг удирдах зөвлөлийн дарга удирдана.¹⁵

2.2.4 Удирдах зөвлөлийн бүрэн эрх:

Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмын төсөл болон тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, асуудалд өгөх зөвлөмж.
- Цэвэр агаар сангийн бүтэц, зохион байгуулалтын талаархи санал.
- Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх талаар санал гаргах гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төсөл, ажлын удирдамж.
- Цэвэр агаарын сангаас санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, тэдгээрийн хэрэгжилт.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт дотоодын болон олон улсын байгууллагаас олгож байгаа санхүүжилтийг уялдуулан зохицуулах асуудал.
- Цэвэр агаарын санд хөрөнгө хуримтлуулах, зарцуулах болон үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал.
- Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой асуудлаар иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх.

¹³ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан

¹⁴ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан

¹⁵ Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дүгээр заалт

- Ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн ажлын тайлан, мэдээлэл.
- Цэвэр агаарын сангийн стратегийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөв болон сангийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан.¹⁶
- Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхээр зохицуулжээ.

Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэдэг.

Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хуралд иргэн, албан тушаалтан, холбогдох этгээдийг оролцуулж, санал, дүгнэлтийг сонсож болно.

Зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөж, тайлангаа хагас, бүтэн жилээр дүгнэнэ. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх зарим тодорхой асуудлаар холбогдох салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.

Зөвлөлийн гишүүд нь хурлаас гарсан шийдвэрт хамтын хариуцлага хүлээх бөгөөд ажлаа байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүр тайлагнахаар зохицуулсан байна.

2.2.4.1 Судалгааны товч дүгнэлт, санал.

Удирдах зөвлөлийн дарга болон орлогч даргаас бусад гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлолгүй орхижээ. Ийнхүү тодорхой шалгуурыг тодорхойлоогүйн улмаас тус зөвлөлд ямар, мэргэжлийн, ямар ч албан тушаалын хүмүүс орж болохоор байгаа юм.

Удирдах зөвлөлийн бүрэн эрхийг судалж үзэхэд санал, дүгнэлт, зөвлөмж өгөх өргөдөл, хүсэлтийг хянаж шийдвэрлэх зэрэг эрх хэмжээнүүд тодорхойлогдсон байна. Харин уг санал, дүгнэлт, зөвлөмжийг хэнд хандаж гаргах, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга механизм, хэрэв зөвлөмжид заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд хэрхэх зэрэг нөхцөл байдлууд тодорхойгүй байгаа юм.

Удирдах зөвлөлийн эрх, хэмжээ нь Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж баримт бичгүүдэд өөр, өөрөөр тусгагдсан асуудал гарч ирж байна. Жишээ нь: Гүйцэтгэх захирлыг томилох эрхийг Цэвэр агаарын сангийн дүрмэнд олгосон байхад харин “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-д энэхүү эрхийг олгоогүй байгаа юм.

Санал:

- 1) Удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах тодорхой шалгуурыг бий болгож, “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон

¹⁶ Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5 дугаар заалт

тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тусгах шаардлагатай бөгөөд энэхүү шалгуур нь мэргэжлийн, албан тушаалын шалгуур байх нь зүйтэй.

- 2) Удирдах зөвлөлийн эрх үүргийг тодорхой болгох, санал, дүгнэлт, зөвлөмжийг хэнд хандан гаргах, хэрхэн хэрэгжүүлэх арга механизмийг тодорхойлох.
- 3) Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгүүдийн нэгдсэн уялдааг хангах.

2.2.5 Гүйцэтгэх захирал

2.2.5.1 Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх:

Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх асуудлыг Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөл шийдэвэрлэнэ.¹⁷

Энэхүү эрхийг удирдах зөвлөлд Цэвэр агаарын сангийн дүрмээр олгосон боловч “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4. “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь “Цэвэр агаарын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий гүйцэтгэх захирлын Зөвлөлийн саналыг үндэслэн томилж, чөлөөлнө” гэж заасан байна.

Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.5.3. “Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх талаар санал гаргах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төсөл, ажлын удирдамж”-ийг хэлэлцэх эрх хэмжээг Удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр зохицуулсан нь Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөл, эсхүл Байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүний аль нь томилж чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх тухай ойлгомжгүй болоод байгаа юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон “Агаарын тухай хууль”-д энэ талаарх зохицуулалт байхгүй байна. Мөн гүйцэтгэх захиралд тавигдах шалгуур, ямар тохиолдолд ажлаас чөлөөлөх талаарх зохицуулалт байхгүй байна.

2.2.5.2 Гүйцэтгэх захирлын эрх зүйн зохицуулалт:

Гүйцэтгэх захирал нь “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам” болон “Цэвэр агаарын сангийн дүрэм, Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах түүнд хяналт тавих, тайлагнах журам” зэрэг эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Мөн гүйцэтгэх захирал нь Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах бөгөөд энэхүү үр дүнгийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах юм.

¹⁷ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан Цэвэр агаарын сангийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8.2-т “Сангийн гүйцэтгэх захирлыг томилж чөлөөлөх”

Ийнхүү үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах, түүнийг дүгнэх харилцааг зохицуулж буй хууль нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль билээ.

2.2.5.3 Гүйцэтгэх захирлын бүрэн эрх:

- Удирдах зөвлөлийн баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах гүйцэтгэлийг хангуулах.
- Төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтмол хянаж, шаардлага тавих.
- Сангийн үйл ажиллагааны жилийн тайланг Удирдах зөвлөлд танилцуулах холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, балансыг гаргах, аудитын дүгнэлт гаргуулах, тайлагнах.
- Удирдах зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах.
- Сангийн ажлын албыг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах.
- Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах, хөндлөнгийн дүгнэлт гаргуулах асуудлаар гэрээ хэлцэл хийх¹⁸.

2.2.5.4 Судалгааны товч дүгнэлт:

Гүйцэтгэх захирлыг томилж чөлөөлөх этгээдийг тодорхой болгох шаардлагатай байна.

Гүйцэтгэх захирал нь зөвлөлийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг. Гэвч Засгийн газрын тусгай сангийн гүйцэтгэх захирал нь төрийн албан хаагч мөн эсэх асуудал нь эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхойгүй байгаа юм. Гүйцэтгэх захирал нь Төрийн албаны тухай хуульд заагдсан төрийн албан хаагчдын ангиллын алинд нь ч хамаарахгүй байх тул уг асуудлыг тодорхой болгох шаардлагатай.

Гүйцэтгэх захирал нь “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам” болон Цэвэр агаарын сангийн дүрэм, “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах түүнд хяналт тавих, тайлагнах журам” зэрэг эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Иймээс Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, үйл ажиллагааны журмыг нэгтгэн зохицуулах шаардлагатай.

Санал:

- 1) Гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх эрхийг Байгаль орчин аялал жуучлалын сайдад олгож, ийнхүү томилохдоо Удирдах зөвлөлийн саналыг үндэслэх.

¹⁸ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан Цэвэр агаарын сангийн дүрмийн 3 дугаар зүйл.

Удирдах зөвлөлийн дарга үр дүнгийн гэрээ байгуулах зохицуулалтыг Цэвэр агаарын сангийн дүрмэнд оруулах.

- 2) Төрийн албаны тухай хуульд Засгийн газрын тусгай сангийн гүйцэтгэх захирлыг төрийн ямар албан хаагчид оруулах талаар өөрчлөлт оруулах.
- 3) Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгүүдийн уялдааг сайжруулан, эрх үүргийн зохицуулалтын давхардалгүй нэгдсэн нэг эрх зүйн актыг гаргах, энэ нь Цэвэр агаарын сангийн дүрэм байх.

2.2.6 Цэвэр агаарын сангийн ажлын алба

2.2.6.1 Ажилчдыг томилж, чөлөөлөх:

Цэвэр агаарын сангийн ажлын албаны ажилчдыг томилж, чөлөөлөх асуудлыг Гүйцэтгэх захирал шийдвэрлэж байна¹⁹.

Ажилтан ажилд орохдоо ажилд орохыг хүссэн өргөдөл, Төрийн албан хаагчийн анкет, Боловсролын диплом, иргэний үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтэр Цагдаагын ерөнхий газрын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт, сүүлийн 6 сарын дотор авахуулсан цээж зураг зэргийг ажилд орохыг хүссэн этгээд бүрдүүлж өгөх²⁰ бөгөөд гүйцэтгэх захирал ажилд томилох тушаал гаргана.

Ажилд томилоход ажилд томилогдсон даруй Цэвэр агаарын сангийн дүрэм байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажил үүргийн хуваарийг танилцуулж хөдөлмөрийн гэрээ байгуулж хөдөлмөрийн харилцааг эхлүүлж байгаа юм²¹.

Харин ажлаас чөлөөлөхөд Хөдөлмөрийн хуулийн 39, 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээс гадна дараах тохиолдлуудад ажлаас халахаар заасан байна. Үүнд:

- Хоёр удаа сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд 3 дахь удаагаа сахилгын шийтгэл хүлээх нөхцөл бүрдсэн.
- Эрүүгийн ялангуяа авилгын гэмт хэрэг үйлдсэн нь эрх бүхий байгууллагаас тогтоосон.
- Албан тушаалаа урвуулан ашиглаж бусдад дарамт шахалт үзүүлсэн, сэтгэл санаа эд материалын ноцтой хохирол учруулсан.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлж залилан мэхэлж ажилд орсон нь тогтоогдсон тохиолдолд тус тус ажилаас халахаар зохицуулжээ.²²

¹⁹ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын сангийн дүрмийн 3 дугаар зүйлийн 2.3.7 "Сангийн ажлын албыг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах"

²⁰ Цэвэр агаарын сангийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын сангийн ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам"-ын 1.1 дүгээр зүйл

²¹ Цэвэр агаарын сангийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын сангийн ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам"

²² Цэвэр агаарын сангийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын сангийн ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам"-ын 1.6 дугаар зүйл

2.2.6.2 Ажлын албаны эрх зүйн зохицуулалт:

Ажлын алба нь Хөдөлмөрийн хуулийн дагуу Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Иймээс Хөдөлмөрийн тухай хууль ажилчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулж байна. 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөрийн 07 тоот тушаалаар Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал “Цэвэр агаарын сангийн ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байх бөгөөд энэхүү дотоод журам нь мөн тус байгууллагын ажлын албаны ажилчдын дагаж мөрдөх журам болж байгаа юм.

Ажлын албаны ажилчидтай гүйцэтгэх захирал “Хөдөлмөрийн гэрээ” байгуулан ажиллаж байгаа учир ажилчид Хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан эрх, үүрэг хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Харин тус сангийн ажлын албаны ажилчид төрийн албан хаагчид хамаарах эсэх асуудал тодорхойгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл Төрийн албаны хуулиар зохицуулагдахгүй байна. Засгийн газрын тусгай сан болох Цэвэр агаарын сан нь Байгаль орчин аялал жуулчлалын яамны харьяалах байгууллага боловч тус сангийн ажилчид төрийн албан хаагч болохгүй байгаа нь анхаарах асуудал болж байна.

2.2.6.3 Ажлын албаны ажилчдын эрх , үүрэг:

Ажилчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан нийтлэг эрх, үүрэг, болон Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал Цэвэр агаарын сангийн ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам болон Хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус сангийн ажилтнууд Хөдөлмөрийн хуулиар олгогдсон нийтлэг эрхийг эдэлж үүргийг хүлээж байна. Үүнд:

- Ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй.
- Ажилтан нь үнэнчээр хөдөлмөрлөх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг сахин биелүүлэх үүрэгтэй²³.

2.2.6.4 Судалгааны товч дүгнэлт, санал

Засгийн газрын тусгай сан болон Цэвэр агаарын санд ажиллаж байгаа ажилтнууд төрийн албан хаагчид хамаарах эсэх, эсхүл Хөдөлмөрийн хуулийн дагуу зохицуулагдах

²³ Хөдөлмөрийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,6.2

эсэх, зэрэг чухам ямар хуулиар эдгээр албан хаагчдын харилцаа зохицуулагдах нь тодорхойгүй байгаагаас ажилчдад олгох хангамж, нөхөн олговор, тэтгэвэр тэтгэмж цалингын хэмжээ зэрэг нөхцөл байдал өнөөг хүртэл тодорхойгүй байна.

Одоогийн байдлаар Хөдөлмөрийн хуулийн дагуу гэрээ байгуулж ажиллаж байгаа ч цаашид энэхүү харилцааг зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журмыг нарийвчлан тодорхойлох Байгууллагын дотоод журмыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна. Одоогийн Хөдөлмөрийн дотоод журманд ажилтан ямар үе шатаар хэрхэн сонгон шалгаруулж авах талаарх зохицуулалт байхгүй байгаа юм.

Санал:

- 1) Засгийн газрын тусгай сангийн ажилчид төрийн албан хаагч эсэх асуудлыг эрх зүйн зохицуулалтын хувьд нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна. Иймээс Төрийн албаны тухай хуульд шууд зохицуулалт оруулах саналыг гаргаж байна.
- 2) Байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловруулах шаардлагатай. Цэвэр агаар сангийн Хөдөлмөрийн дотоод журманд хийсэн дэлэгрэнгүй судалгааг энэхүү судалгааны хоёр дугаар бүлэгт тодорхой заасан болно.
- 3) Боловсон хүчний бодлогыг тодорхойлж ажилтан сонгон шалгаруулах журмыг нарийвчлан зохицуулах, үүнийг Хөдөлмөрийн дотоод журманд оруулах.

3 Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах тайлагнах, хяналт тавих

3.1 Санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Цэвэр агаарын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хууль, Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”, Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам” мөн тушаалаар батлагдсан Цэвэр агаарын сангийн дүрэм зэрэг хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

3.2 Цэвэр агаарын сангийн эх үүсвэр

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын дагуу Цэвэр агаарын сангийн эх үүсвэрийн зонхилох хэсэг улсын төсвөөс бүрдэх тусгай сангийн төрөлд хамаардаг бөгөөд Цэвэр агаарын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна.

- Улсын төсвийн хөрөнгө.
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив.
- Гадаад улс, олон улсын байгууллагаас ЗГ-ын шугамаар олгосон зээл.
- Агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөр.
- Төрийн сангийн тусгай дансанд байршиж байгаа сангийн хөрөнгийн үлдэгдэлд олгосон хүү.
- Бусад орлого²⁴.

3.3 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах

Цэвэр агаарын сангийн хөрөнгийг дараах төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулахаар зохицуулсан байна. “Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх арга хэмжээг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д тодорхой заасан бөгөөд Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д мөн зарим арга хэмжээг нэмж оруулжээ.

Цэвэр агаарын сан нь дараах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.

- Агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

²⁴ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 4.1 дүгээр заалт

- Стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих тэдгээрийг худалдан авахад татаас олгох.
- Агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, ажлыг гүйцэтгэх.
- Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.
- Сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.
- Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах.
- Сангийн урсгал зардал, үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг сангийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр гаргах. /журамд нэмж заасан²⁵/
- Хандивлагч орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт зориулалтыг нь тусгайлан заасан тохиолдолд зориулалтын дагуу зарцуулна. /журамд нэмж заасан/

3.3.1 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах, тайлагнах.

Цэвэр агаарын сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах эрх бүхий этгээд:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д зааснаар хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Байгаль орчин, аялал жуучлалын сайд гаргана.

Байгаль орчин аялал жуучлалын сайдын Цэвэр агаарын санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг Сангийн яам Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.

Цэвэр агаарын сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоохоор зохицуулжээ²⁶.

²⁵ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн а-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 4.2.8

²⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт

3.3.2 Цэвэр агаарын сангийн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөх, тайлагнах.

Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сангийн Удирдах зөвлөлийн саналыг тусгах замаар сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг хянан боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд өөрийн багцад оруулан төлөвлөж тайлагнана.

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгахаар зохицуулсан байна²⁷.

Сангийн орлого зарлагын нэгдсэн тайланг улирал бүрээр гаргаж дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус тайлагнахаар зохицуулсан байна²⁸.

Ийнхүү тайлагнахдаа Цэвэр агаарын сан зарцуулалтын тайландаа Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Үндэсний аудитын газар, улсын мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулах шаардлагатай байхаар журамласан байна²⁹. Цэвэр агаарын сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлэх бөгөөд олон улсын гэрээний дагуу байгуулагдсан тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг хандивлагч талд өгөхийн зэрэгцээ түүнд аудит хийх боломж олгох юм³⁰.

3.3.3 Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

3.3.3.1 Улсын их хурал

Хяналтийг хэрэгжүүлэх байгууллага

Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байхаар хуульчилсан³¹. Цэвэр агаарын сангийн хувь Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо хамаарч байна.

Хяналт шалгалт хийх үндэслэл

Улсын Их Хурлын байнгын хороо нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болохоор заасан байна.

²⁷ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ын 5.1 дэх заалт

²⁸ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ын 6.1

²⁹ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ын 6.1,

³⁰ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ын 6.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7

³¹ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт

Ямар тохиолдлыг шаардлагатай гэж үзэх талаарх нарийвчилсан тодорхой зохицуулалт байхгүй учир тухайн асуудал эрхэлсэн байнгын хороо нь өөрийн үзэмжээр тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болох юм.

Санхүүгийн хяналт, шалгалт хийх чиглэл

Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нь тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэх юм.

Хууль тогтоомжид Улсын Их Хурал чухам ямар чиглэлээр хэлэлцэх талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

3.3.3.2 Засгийн газрын хяналт, шалгалт

Хяналтийг хэрэгжүүлэх байгууллага

Засгийн газар нь тусгай санд хяналт шалгалт хийх эрхтэй бөгөөд Засгийн газрын санхүүгийн дотоод хяналт шалгалтыг хяналт, шалгалтын мэргэжлийн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Санхүүгийн хяналт, шалгалтад төрийн захиргааны болон Засгийн газраас байгуулдаг бусад байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдах бөгөөд үүнд Засгийн газрын тусгай сан болох Цэвэр агаарын сан хамаарч байгаа юм.

Хяналт шалгалт хийх үндэслэл

Энэхүү санхүүгийн хяналт, шалгалтыг байгууллагын хүсэлт, дээд шатны байгууллагын шийдвэрээр хийж болохоор хуульчилсан.³²

Харин ямар байгууллагын хүсэлтээр хяналт шалгалт хийх нь тодорхойгүй байх тул дурын байгууллага хүсэлт гаргаж тус санд хяналт шалгалт хийлгэх боломжтой байгаа юм.

Мөн дээрх заалтаас үзэхэд иргэн хяналт шалгалт хийлгэх хүсэлт гаргах эрхгүй болж байна.

Дээд шатны байгууллага хяналт шалгалт хийлгэх шийдвэр гаргасан тохиолдолд хяналт шалгалт хийхээр заасан бөгөөд энэ нь Цэвэр агаарын сангийн хувьд Байгаль Орчин аялал, жуучлалын яам болж байна.

Санхүүгийн хяналт, шалгалт хийх чиглэл

Мэргэжлийн хяналтын газар нь доорх чиглэлээр хяналт шалгалт хийнэ.

- Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.

³² Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-64.5 дугаар зүйлүүд

- Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт.
- Өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт.
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал.
- Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт.
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан.
- Гадаад улс орон, олон улсын байгууллага, Засгийн газрын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт.
- Улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт.
- Дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт.
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

3.3.3.3 Сангийн яам

Хяналт хэрэгжүүлэх байгууллага

Сангийн яамны хяналтыг төлөөлж хэрэгжүүлэх этгээдийг тодорхойлон хуульчлаагүй. Иймээс Сангийн яам хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Сангийн яамны дэд сайд нь Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн орлогч дарга байхаар зохицуулсан.

Орлогч дарга нь зөвлөлийн даргын эзгүйд зөвлөлийг удирдахаар “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-д заажээ. Энэ агуулгаар авч үзвэл тус яам төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой байна.

Хяналт шалгалт хийх үндэслэл

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хяналт хийнэ. Мөн Сангийн яамны дэд сайд нь төлөөлөн удирдах зөвлөлийн орлогч дарга, гишүүний хувьд Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журамд заасан зөвлөлийн хэлэлцэх асуудлын хүрээнд сангийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой байна.

Удирдах зөвлөл нь Цэвэр агаарын сангийн хөрөнгө хуримтлуулах, зарцуулах болон үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, сангийн санхүүгийн тайлан, сангийн

үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам зэргийг хэлэлцдэг бөгөөд эдгээр бүхий л хэлэлцэж буй асуудлын хүрээнд санал өгөх, саналаа илэрхийлэх боломжтой байгаа нь сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бий болгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Цэвэр агаарын сангийн өөрийн багцад оруулан төлөвлөж тайлагнах бөгөөд Сангийн яам нь уг, орлого зарлагыг хянаж улсын төсвийн төлөвлөгөөнд тусгадаг³³.

Хуульд сангийн яам яг ямар үндэслэл нөхцөлөөр хяналт тавих, хяналтийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа юм.

Хяналт шалгалт хийх чиглэл

Сангийн яам нь төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхэд хамаарах улсын төсвийн байгууллагын бүтээгдэхүүний нийлүүлэлт болон улсын төсвийн хөрөнгөөр орон нутгийн байгууллагаас худалдан авах бүтээгдэхүүний нийлүүлэлтийн явцад хяналт тавих эрхтэй юм.³⁴ Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчаас төлөвлөж ирүүлсэн Цэвэр агаарын сангийн орлого зарлагыг хянана.

Дээр дурьдсанаас өөр яг ямар чиглэлээр хяналт шалгалт хийх талаарх нарийвчилсан тодорхой зохицуулалт хууль, тогтоомж³⁵-д байхгүй байна.

3.3.3.4 Төрийн аудитын газар

Хяналт хэрэгжүүлэх байгууллага

Төрийн аудитыг төрийн аудитын байгууллага хэрэгжүүлдэг. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

Төрийн аудитын төв байгууллага нь Үндэсний аудитын газар, орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлийн аудитын газар байдаг .

Хяналт шалгалт хийх үндэслэл

Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргахыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д хуульчилж өгсөн байна.

Санхүүгийн хяналт, шалгалт хийх чиглэл

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага

³³ Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан Цэвэр агаарын сангийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан.

³⁴ Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт

³⁵ Хууль тогтоомж гэдэгт энэхүү судалгааны ажлын хмрах хүрээнд одорхойлогдсон хууль тогтоомжуудыг ойлгох нь зүйтэй.

иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүнд аудит хийх эрхийн дагуу аудитын үйл ажиллагаа явуулдаг³⁶.

3.4 Судалгааны товч санал, дүгнэлт

3.4.1 Цэвэр агаарын сангийн эх үүсвэрийн талаар

Судалгааны товч дүгнэлт, санал:

Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.-д Цэвэр агаарын сангийн эх үүсвэрүүдийг тодорхойлсон байдаг бөгөөд үүний 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “бусад орлого” гэж заасан байна.

Энэхүү “бусад орлого” гэсэн нь чухам ямар орлого багтаж болох талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс зохицуулалтын хувьд ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож байгаа юм.

Санал:

Цэвэр агаарын сангийн эх үүсвэрийг ямар нэгэн хоёрдмол утга агуулгагүй шууд зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

3.4.2 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах талаар:

Судалгааны товч дүгнэлт, санал:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-д Цэвэр агаарын сангийн санхүүжүүлэх арга хэмжээг нэг бүрчлэн тодорхой заасан бөгөөд харин “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.8. “Сангийн урсгал зардал, үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг сангийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр гаргах” мөн журмын 4 дүгээр зүйлийн 4.2.9-д “Хандивлагч орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт зориулалтыг нь тусгайлан заасан тохиолдолд зориулалтын дагуу зарцуулна.” гэсэн зүйлүүдийг нэмсэн байна.

Байгаль орчин аялал жуучлалын сайд нь журам гаргахдаа хуульд нийцүүлэн гаргах ёстой бөгөөд хуульд заагдаагүй, хуулиар зохицуулагдаагүй асуудлыг шууд зохицуулсан нь хуультай зөрчилдөж байгаа юм.

Санал:

“Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ыг хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

³⁶ Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт

3.4.3 Цэвэр агаарын сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах, тайлагнах талаар:

Судалгааны товч дүгнэлт, санал:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д зааснаар хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Байгаль орчин, аялал жуучлалын сайд гаргахаар зохицуулсан байдаг. Гэтэл “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.8. “Сангийн урсгал зардал, үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг сангийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр гаргах” гэж заасан нь уг заалттай зөрчилдөж байгаа юм. Өөрөөр хэлбэл удирдах зөвлөл нь Үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг гаргах шийдвэр гаргахаар зохицуулсан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байгаа юм.

Цэвэр агаарын сангийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8.6. “Сангийн үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын тайланг холбогдох Засгийн газрын гишүүн болон бусад байгууллагад хүргүүлэх” гэж заасан байх бөгөөд харин Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сангийн Удирдах зөвлөлийн саналыг тусгах замаар сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг хянан боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд өөрийн багцад оруулан төлөвлөж тайлагнана.

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгахаар зохицуулсан байна³⁷. Энэхүү хоёр журмын зохицуулалт хоорондоо зөрчилдөж байгаа юм.

Санал:

“Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д заасан Удирдах зөвлөлийн эрх хэмжээг тодруулах, Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журмыг өөр хоорондын зөрчлийг арилгах, хуульд нийцүүлэх.

3.4.4 Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаар:

Судалгааны товч дүгнэлт, санал:

Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нь “Шаардлагатай” гэж үзсэн тохиолдолд тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болохоор заасан нь мөн зохицуулалтын хувьд тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож байгаа юм. Чухам ямар тохиолдлыг шаардлагатай гэж үзэх нь ойлгомжгүй байна.

Засгийн газар санхүүгийн хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ мэргэжлийн хяналтын газраар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд Санхүүгийн хяналт, шалгалтыг байгууллагын

³⁷ дэх заалт

хүсэлт, дээд шатны байгууллагын шийдвэрээр хийж болохоор хуульчилсан. Энэхүү хяналт шалгалтын байгууллагын хүсэлтээр хийж болохоор заасан нь чухам ямар байгууллага хамаарах, иргэн хүсэлт гаргах боломжтой эсэх, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх зэрэг нөхцөл байдлууд тодорхойгүй байгаа юм.

Сангийн яам нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуульд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчийн гаргасан тайлан төлөвлөгөөг хүлээн авч хяналт тавьдаг байгууллага бөгөөд хуульд сангийн яам яг ямар үндэслэл нөхцөлөөр хяналт тавих, хяналтийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа юм. Гэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх хэмжээ нь хуульчлагдсан боловч хэрхэн хяналт тавих нөхцөл байдал нь тодорхойгүй байна.

Санал:

- 1) Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нь ямар үндэслэлээр тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэх талаарх нарийвчилсан зохицуулалтыг хуулинд оруулах, эсхүл дээд шүүхээс “Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд” гэсэн ойлголтыг тайлбарлаж нэг мөр ойлгох, хэрэглэхэд ойлгомжтой болгох шаардлагатай гэж дүгнэв.
- 2) Мэргэжлийн хяналтын газар тусгай санд хяналт шалгалт хийх үндэслэлийг тодорхой болгож хуулинд оруулах шаардлагатай гэж үзэж байна.
- 3) Сангийн яам нь төсвийн ерөнхийлөн захирагчид хяналт тавих эрх хэмжээтэй боловч мөн хяналт тавих механизм тодорхойгүй байх тул хяналт тавих арга механизмын нарийвчлан зохицуулах шаардлагатай.

3.5 Цэвэр агаарын сан бусад байгууллагатай харилцах

3.5.1 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо

3.5.1.1 Үндэсний хороо байгуулагдсан эрх үйн үндэслэл

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/ байгуулагдах хууль зүйн үндэслэл нь 2011 оны 02 дугаар сарын 11-ны өдөр батлагдсан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог байгуулж ажиллуулах” бүрэн эрхийг Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааруулан хуульчилж өгсөн байна.

Мөн уг хуулиар Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар батлахаар зохицуулсан юм. Энэ нь уг Үндэсний хорооны байгуулагдах хууль зүйн үндэслэл болж байна.

3.5.1.2 Үндэсний хорооны эрх зүйн зохицуулалт

Үндэсний хороо нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, болон Ерөнхийлөгчийн зарилгаар баталсан Үндэсний хорооны бүрэлдэхүүн болон ажиллах журам³⁸ бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа болно.

3.5.1.3 Үндэсний хорооны бүрэн эрх

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаарх салбар дундын бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавих.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажил, ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай холбогдох албан тушаалтны сонсгол тайланг авч хэлэлцэх, мэдээ тайлан гаргуулах.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний жилийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж биелэлтэд хяналт тавих.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгийн тооцоо, эх үүсвэрийн асуудлыг уялдуулан зохицуулж санхүүжилтэд хяналт тавих.
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах.
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа дотоод, гадаадын төсөл хөтөлбөр, сангийн үйл ажиллагааны нэгдсэн мэдээлэл судалгааны санг бүрдүүлж харилцан уялдааг хангаж зохицуулах.
- Агаарын чанарын мэргэжлийн албадын үйл ажиллагааг удирдан чиглүүлж нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай судалгаа, мэдээллийг гаргуулан авах.
- Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжиж урамшуулах, агаарын төлөв байдлын тухай нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад үр дүнгээ өгч буй арга хэмжээг бусад аймгийн төв, хот суурин газарт хэрэгжүүлэх талаархи саналаа холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, арга зүйн туслалцаа үзүүлэх, хамтран зохион байгуулах.

³⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 03 сарын 03 өдрийн 43 дугаар зарлиг

- Нийслэлийн болон бусад хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний талаар саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл боловсруулах, санал гаргах.

3.5.1.4 Цэвэр агаарын сантай харилцах

Үндэсний хороо нь Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй үйл ажиллагааг нэгтгэх, төрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны хүрээнд Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар зөвлөмж зааварчилгаа өгөх, нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Иймээс бүрэн эрхээ хэрэгжүүлж Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд оролцож байгаа болно.

Үндэсний хорооны ажиллах журмаас үзэхэд Үндэсний хороо болон Цэвэр агаарын сан нь хоорондоо дараахи хэлбэрүүдээр харилцаж байна гэж тодорхойлж болохоор байна. Үүнд.

- *хяналт тавих,*
- *санал гаргах,*
- *үүрэг болгох,*
- *зохицуулах,*
- *сонсгол, тайланг авч хэлэлцэх,*
- *мэдээ тайлан гаргуулах,*
- *саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх,*
- *арга зүйн туслалцаа үзүүлэх,*
- *шаардлагатай арга хэмжээг авах,*

Судалгааны товч дүгнэлт, санал

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь одоогоор зөвхөн Ерөнхийлөгчийн зарилгаар батлагдсан “Үндэсний хорооны бүрэлдэхүүн болон ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Харин Агаарын тухай хууль, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хуульд тус хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг зохицуулаагүй байгаа юм. Иймээс Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь:

- *хяналт тавих,*
- *санал гаргах,*
- *үүрэг болгох,*
- *зохицуулах,*
- *сонсгол, тайланг авч хэлэлцэх,*
- *мэдээ тайлан гаргуулах,*
- *саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх,*
- *арга зүйн туслалцаа үзүүлэх,*
- *шаардлагатай арга хэмжээг авах*

гэх мэт хэлбэрүүдээр бусад байгууллагатай харилцах боловч эдгээр бүхий л хэлбэрүүд хэрхэн хэрэгжих, арга механизм хууль болон журманд зохицуулагдаагүй байгаа юм. Өөрөөр хэлбэл “Зохицуулах” гэдэг нь ямар эрх хэмжээний хүрээнд хэрхэн хийгдэх арга зүйн туслалцаа үзүүлэх нь мөн ямар арга хэлбэрээр хэрэгжих гэх мэт нарийвчилан зохицуулах шаардлагатай зүйлүүд тус хорооны эрх зүйн зохицуулалтад нилээд их байна.

Санал:

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны үйл ажиллагаа явуулах эрх хэмжээ, түүний хэрэгжих арга хэлбэрийг нарийвчлан тодорхойлж зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний тулд Агаарын тухай хуулийн шинэчилсэн төсөлд тус хорооны үйл ажиллагааг нарийвчилан зохицуулж өгөх шаардлагатай байна.

3.5.2 Нийслэлийн Агаарын чанарын алба

3.5.2.1 Агаарын чанарын алба байгуулагдсан эрх зүйн үндэслэл.

Нийслэлийн агаарын чанарын алба нь 2006 оны 10-р сард Нийслэлийн Засаг даргын 444 дүгээр захирамжаар Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дэргэд Агаарын чанарын алба 7 хүний бүрэлдэхүүнтэй анх байгуулагдсан. 2009 оны 1-р сарын 23-нд Монгол Улсын засгийн газрын 68-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын 14-р тогтоолоор 16 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болж үйл ажиллагаагаа явуулж байна.

3.5.2.2 Агаарын чанарын албаны эрх зүйн зохицуулалт

Нийслэлийн агаарын чанарын алба нь Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх зүйн үндсэн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, болон Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.5.2.3 Агаарын чанарын албаны бүрэх эрх

- Агаарын чанарыг тодорхойлох, хяналт-шинжилгээ хийх, холбогдох мэдээ, дүгнэлт гаргах үүрэг бүхий агаарын чанарын мэргэжлийн албыг төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж ажиллуулна.
- Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар байгуулах асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн байгаль, цаг уурын онцлог, үйлдвэржилтийн түвшинтэй уялдуулан төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэж, тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.
- Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу Засаг даргын удирдлага дор ажиллана.
- Озоны үе давхаргыг хамгаалах талаархи олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, холбогдох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн алба зохион байгуулна.

- Мэргэжлийн албаны ажилтан хэмжилт, судалгаа, шинжилгээ хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох эрхтэй³⁹.

Тус албаны үндсэн үүрэг, зорилт нь агаарын чанарыг тодорхойлох, хяналт, шинжилгээ хийх, холбогдох мэдээ гаргах, бохирдлыг бууруулах, багасгах болон агаар хамгаалах талаар төр, засаг, нийслэлийн удирдлагуудаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, хөтөлбөр, стандартын төсөл боловсруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг.⁴⁰

3.5.2.4 Цэвэр агаарын сантай харилцах

Нийслэлийн агаарын чанарын албаны гүйцэтгэж байгаа зарим үйл ажиллагааг Цэвэр агаарын сангаас санхүүжүүлж байна.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам, Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг хороо, иргэдэд хүргэх журам Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам зэрэг журмуудаар Цэвэр агаарын сангийн санхүүжүүлэх үйл ажиллагаанууд болон бусад үйл ажиллагааг зохицуулсан байна.

Цэвэр агаарын сан нь Агаарын чанарын албатай харилцахдаа:

- санхүүжүүлэх,
- хяналт тавих,
- тооцоо нийлэх,
- урамшуулал олгох,
- санхүүгийн баримтаар хангах гэсэн хэлбэрүүдээр харилцаж байна.

Дээр дурьдсан журмуудаар Цэвэр агаарын сангийн санхүүжүүлэх үйл ажиллагаа болон бусад оролцоог хүснэгтээр харуулав.

“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам”-ын дагуу Цэвэр агаарын сантай харилцах.

Д/д	Журам хэрэгжүүлэгч	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотын захирагчийн алба • Нийслэлийн мэргэжлийн хяналтын алба • Агаарын чанарын алба, дүүрэг хорооны засаг дарга нар
-----	--------------------	---

Д/д	Хязгаарлалтийн бүсэд хяналт тавих	
	Журмын хэрэгжилтэнд хяналт тавих	Нийслэл, Дүүргийн мэргэжлийн хяналтын газар болон эрх бүхий албан тушаалтан /Агаарын чанарын хяналтын алба болох Нийслэлийн Агаарын чанарын албаны мэргэжилтнүүд, дүүрэг хорооны Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч нар/
	Хэрэгжүүлэгч	Үйл ажиллагаа
	Бүсэд бүрэн хяналт тавин ажиллах этгээд Хязгаарлалтын бүсэд	

³⁹ Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1

⁴⁰ <http://airquality.ub.gov.mn/>

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн судалгаа

	оршин хороодын хэсгийн ахлагч нь /агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагч юм./	
	Улсын агаарын чанарын мэргэжлийн алба, Нийслэлийн агаарын чанарын алба	Агаарын бохирдлын хэмжилт болон дүгнэлтийг гаргана
	Агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагч	“Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс” –ийн айл өрхийн мэдээллийг гаргана. Энэхүү мэдээллийг Нэгдсэн мэдээллийн санд нийслэлийн агаарын чанарын алба оруулна.
	Аж ахуй нэгж байгууллага	Агаарын бохирдлын томоохон эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан мэдээг Агаарын тухай хуулийн 10.4-т заасны холбогдох албанд ирүүлнэ.
	Цэвэр агаар сан	Агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагчдад сар бүр урамшуулал олгох

Боловсруулсан түлш нөөцлөх дүүрэг, хороо, игэдэд хүргэх журам

д/д	Хэрэгжүүлэгч	Үйл ажиллагаа	Санхүүжилт
	Нийслэлийн агаарын чанарын алба	Коксон түлш, үртсэн шахмал түлшийг хадгалах	Цэвэр агаарын сан хариуцна.
		Түлшний хөнгөлөлтийн ваучер хэлбэрээр олгох	Цэвэр агаарын сан хариуцна.
	Агаарын бохирдлын хяналтын орон тооны бус байцаагчид	Бүсэд бүрэн хяналт тавьж ажиллана	

д/д	Боловсруулалт түлшний нөөц хадгалах		
	Хэрэгжүүлэгч	Үйл ажиллагаа	Санхүүжилт
	Нийслэлийн агаарын чанарын алба	Цэвэр агаарын сангаас баталсан мөнгөн дүнд багтаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагаас шаардлага хангасан түлшийг гэрээний үндсэн дээр худалдан авах хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Санхүүжилт “Цэвэр агаарын сан” батлана.
	Нийслэлийн агаарын чанарын алба	Нийслэлийн агуулахад нөөцлөгдсөн түлшийг төвлөрсөн борлуулалтын цэгт хүргэх ажлыг хариуцна.	
	Нийслэлийн агаарын чанарын алба	Түлш хүлээлцэх акт болон тайлангийн маягттай байх ба энэхүү хуваарийг агаарын чанарын алба батлан хэрэгжилтийг хангуулж ажиллана.	
	Нийслэлийн агаарын чанарын алба	Тухайн жил нөөцлөгдөхөөр батлагдсан түлшний хэмжээ нийлүүлэлтийн явцад нэмэгдсэн тохиолдолд тэдгээрийг худалдан авах, дахин нөөц бүрдүүлэх талаархи саналаа Цэвэр агаарын сангийн удирдах зөвлөлөөр дамжуулан шийдвэрлүүлнэ.	
		Стандартын шаардлага хангасан агуулахад түлшийг хадгалах бөгөөд агуулахын түрээс, төвлөрсөн борлуулалтын цэгт хүргэх тээвэрлэлтийн зардлыг	Цэвэр агаарын сан хариуцна.

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн судалгаа

Цэвэр агаарын сан	Санхүүгийн баримтыг Цэвэр агаарын сангаас хангах ба бүртгэл тооллогонд тогтмол хяналт тавьж ажиллана.	
Агаарын бохирдлыг бууруулах салбар хороо	Борлуулалтын тайланг Засаг даргаа 7 хоног бүр гаргуулан нэгтгэж Нийслэлийн агаарын чанарын алба, Цэвэр агаарын сантай тооцоо нийлж байна.	
Орон тооны бус байцаагч	Борлуулалтын орлогыг Цэвэр агаарын санд тушаана.	
Агаарын бохирдлыг бууруулах салбар хороо, Цэвэр агаарын сан хамтран	Түлш борлуулах цэгүүдэд Нэгдсэн хаягжуулалт хийх ажил	
Хяналт		
Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, агаарын бохирдлыг бууруулах салбар хороо, орон тооны бус байцаагч болон Цэвэр агаарын сан хяналт тавьж ажиллана	Нөөцийн түлш хүлээн авах, хадгалах, борлуулах үйл ажиллагаанд	
Нийслэлийн агаарын чанарын алба байна.	Аж ахуй нэгж байгууллагаас гэрээний дагуу нийлүүлэгдэж байгаа түлшний чанарт стандартын дагуу хийгдсэн шинжилгээний үр дүнд хийгдсэн шинжилгээний үр дүнд хяналт тавих байгууллага	
Агаарын бохирдлыг бууруулах салбар хороо, хороодын засаг дарга, орон тооны бус байцаагч хяналт тавина	Түлшний борлуулалтын үнэ, борлуулалтанд	
Дүүргүүдийн онцгой байдлын хэлтэс хяналт тавина.	Түлш борлуулах цэгүүдэд галын аюулгүй байдлыг хангах ажиллагааг	
Тайлан		
Хэрэгжүүлэгч	Үйл ажиллагаа	Хяналт тавих
Нийслэлийн агаарын чанарын алба нь	Агуулахад байгаа болон борлуулалтын цэгүүдээр зарагдсан түлшний хэмжээ, түүний чанар хэмжээг харуулсан тайланг нэгтгэн сар бүрийн 25 нд	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, БОАЖЯ, Нийслэлийн засаг даргад тайлагнах

Судалгааны товч дүгнэлт:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдын тэргүүлэгчдийн хурал нь нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхийг гэр, байшингийн дулаалга, сайжруулсан зуух, агаар бохирдуулдаггүй шахмал,

хагас коксон болон шингэрүүлсэн хийн түлшээр хангах асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй⁴¹ болохыг Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуульд заажээ.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурал нь агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дараах журмуудыг баталсан. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 131 тоот тогтоолоор “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам” баталсан байх бөгөөд энэхүү журмын зорилго нь “...*Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын үндсэн болон дэд бүсэд орших айл өрхийг стандартын шаардлага хангасан боловсруулсан түлш /цаашид “түлш” гэх/ -ээр хангахад нөөцийг бий болгох зорилгоор түлшийг хүлээн авах, хадгалах, түгээх, борлуулах, түгээлтэнд хяналт тавих, түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, дүүрэг, хороодын Нутгийн захиргааны байгууллага, БОАЖЯ-ны Цэвэр агаарын сан, борлуулагчид хоорондын харилцааг зохицуулахад оршино.*” гэсэн байх бөгөөд журмын 1.3. “*Түлшний хөнгөлөлтийг иргэдэд ваучер хэлбэрээр олгох бөгөөд санхүүжилтийг БОАЖЯ-ны Цэвэр агаарын сан бүрэн хариуцна.*” гэсэн байна.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид нь Цэвэр агаарын сангийн хөрөнгийг ямар үндэслэлээр ийнхүү захиран зарцуулах тухай шийдвэр гаргаж байгаа нь ойлгомжгүй байгаа юм.

Цэвэр агаарын сангийн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр захиран зарцуулах бөгөөд сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг авах ёстой билээ. Гэтэл Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид журам гарган түүндээ Цэвэр агаарын сангаас санхүүжүүлнэ хэмээн шууд зохицуулалтанд оруулсан нь хууль зүйн хувьд зөрчилтэй нөхцөл байдлыг бий болгож байгаа юм.

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлд Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж өгөсөн бөгөөд уг зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д “Агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх” гэсэн байна.

Дээрх хуулийн заалтаар Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурал нь нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрхтэй байгууллага байх бөгөөд харин Цэвэр агаарын сангийн хөрөнгийг захиран зарцуулах, уг хөрөнгөөр санхүүжүүлэхээр дангаараа журамлах эрх хэмжээ байхгүй, энэ нь Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны сайдын эрх хэмжээний асуудлыг журамлан шийдвэрлэсэн болж байгаа юм.

Энэ нь Цэвэр агаарын сан болон нутгийн өөрөөр удирдах байгууллагын хоорон дахь харилцаанд буруу эрх зүйн жишиг тогтоож байгаа бөгөөд аль нэг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид өөрийн орон нутагт дагаж мөрдөх журам гаргаад

⁴¹ *Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3. “нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхийг гэр, байшингийн дулаалга, сайжруулсан зуух, агаар бохирдуулдаггүй шахмал, хагас коксон болон шингэрүүлсэн хийн түлшээр хангах асуудлыг шийдвэрлэх”*

түүнийг засгийн газрын тусгай сангаас санхүүжүүлэхээр тусгах явдал цаашид гарч болзошгүй байгаа юм.

Санал:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурал ямар хамтын ажиллагааны зөвшилцөл, гэрээ хэлцэл эрх зүйн баримтыг үндэслэн өөрсдийн баталж буй журамд зарим нэгэн зардлуудыг Цэвэр агаарын сан хариуцахаар зохицуулсан нь ойлгомжгүй байх тул хамтын ажиллагааны хүрээг тодорхойлж, асуудлыг тодорхой болгож журамлах, эрх хэмжээг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

3.6 Аж, ахуйн нэгжтэй харилцах

3.6.1 Аж ахуйн нэгж, байгууллагын эрх зүйн зохицуулалт

Аж ахуйн нэгж нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх сонгон шалгаруулалтад оролцож, улмаар Цэвэр агаарын сангаас санхүүжүүлж байна.

3.6.2 Аж ахуйн нэгжийн бүрэн эрх

Аж ахуйн нэгж нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Цэвэр агаарын сантай харилцах

Цэвэр агаарын сантай сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн аж ахуйн нэгж нь гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Өөрөөр хэлбэл Цэвэр агаарын сан нь захиалагч болон гэрээ байгуулж байгаа болно.

Цэвэр агаарын сан нь аж ахуйн нэгжтэй харилцахдаа

- *санхүүжилт өгөх,*
- *хяналт тавих* гэсэн хоёр үндсэн чиг үүргийн хүрээнд харилцаж байна.

Судалгааны товч дүгнэлт:

Цэвэр агаарын сан нь сонгож шалгаруулалтад оролцож шалгарсан аж, ахуйн нэгж байгууллагын санхүүжилтыг хийх бөгөөд харин хэрхэн хяналт тавих, мөн ямар хариуцлага тооцож болох талаарх зохицуулалт хууль тогтоомжид байхгүй байгаа юм.

Санал:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгай сан санхүүжүүлэгч байгууллагад хэрхэн хяналт тавих, ямар хариуцлага тооцож болох талаар зохицуулалт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

4 Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох

4.1 Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, хариуцлага

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”, мөн зүйлийн 32.2-д “Олон улсын гэрээнд тухайн сангийн дансыг арилжааны банкинд байршуулахаар зааснаас бусад тохиолдолд тусгай сангийн дансыг төрийн сангаас гадуур байршуулахыг хориглоно.” гэж тус тус заажээ.

Эдгээр нь тусгай сангийн хүрээнд тусгайлан хориглох зүйлийг онцлон хуульд заасан бөгөөд Цэвэр агаарын сан нь үйл ажиллагаагаа Монгол улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэн явуулах ёстой юм. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д нарийвчилан зааж өгсөн байна. Үүнд:

- Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулах.
- Олон улсын гэрээнд тухайн сангийн дансыг арилжааны банкинд байршуулахаар зааснаас бусад тохиолдолд тусгай сангийн дансыг төрийн сангаас гадуур байршуулах.
- Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх.
- Сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хөрөнгийн баталгаа гаргах.
- Сангийн үйл ажиллагаатай холбоогүй асуудлаар сангийн хөрөнгөөр хандив өргөх төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, санхүүжүүлэх.
- Батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулах⁴² зэргийг хориглосон байна.

Судалгааны товч дүгнэлт, санал:

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-н 7 дугаар зүйлийн 7.1.1-д “ Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх”, 7 дугаар зүйлийн 7.1.2-д “ Сангийн

⁴² “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан

хөрөнгийг бусдад барьцаалах, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хөрөнгийн баталгаа гаргах”, 7 дугаар зүйлийн 7.1.3-д “ Сангийн үйл ажиллагаатай холбоогүй асуудлаар сангийн хөрөнгөөр хандив өргөх, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх санхүүжүүлэх” гэх мэт Засгийн газрын тусгай сангийн хуульд тодорхойлон заагаагүй зохицуулалтыг бий болгожээ.

Эдгээр нь тусгай сангийн үйл ажиллагаанд хориглогдож болох бөгөөд ийнхүү нарийвчлан зохицуулалт оруулж болох хэдий ч хариуцлага тооцоход хүндрэлтэй болж байгаа юм. Эдгээр нь яг тухайлан хуульд заагдаагүй тул Засгийн газрын тусгай сангийн тухай хууль зөрчсөн гэж үзэхэд хүндрэлтэй болж байна.

Санал:

“Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д заасан дээрх хориглох зүйлүүдийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага тооцох талаар эрх зүйн зохицуулалт оруулах шаардлагатай. Иймээс уг журамд хариуцлагын тодорхой зааж өгөхгүй бол хуульд эдгээр хориглох зүйлүүд байхгүй байна.

4.1.1 Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу хүлээлгэх хариуцлагыг тус хуулийн 33 дугаар зүйлээр зохицуулсан байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасныг зөрчсөн⁴³, эсхүл тусгай сангийн хөрөнгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ашигласан, зарцуулсан, санхүүжилтийг өөр байгууллагад олгосон албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан 40000-60000 хүртэл төгрөгөөр торгоно. Мөн эрх бүхий улсын байцаагч энэ хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг 200000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000 төгрөгөөр тус тус торгоно.

Мөн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 65 дугаар зүйлд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байна. Үүнд:

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг байгууллага, хувь хүн нотлох баримтын хамт төрийн албаны төв байгууллагад ирүүлж болно. Төрийн албаны төв байгууллага нь энэ мэдээллийн дагуу шалгаж эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь арга хэмжээ авна.

- Илэрсэн зөрчлийг арилгуулах.
- Шаардлагатай бол ерөнхий менежерийг албан тушаалаас чөлөөлөх тухай саналаа эрх бүхий байгууллагад тавих.

⁴³ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.”, мөн зүйлийн 32.2-д “Олон улсын гэрээнд тухайн сангийн дансыг арилжааны банкинд байршуулахаар зааснаас бусад тохиолдолд тусгай сангийн дансыг төрийн сангаас гадуур байршуулахыг хориглоно”

- Ерөнхий менежерийн ажлыг дүгнэх, урамшуулахад зөрчлийг харгалзан үзэх.
- Төсвийн байгууллагын ерөнхий менежерээс бусад албан тушаалтан хууль зөрчсөн бол түүнд арга хэмжээг авахуулахаар тухайн байгууллагын удирдлагад санал болгох.

Мөн тус хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн нь тухайн албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болохоор заасан байна.

Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.⁴⁴

4.1.2 Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа дуусгавар болох:

4.1.2.1 Татан буулгах хууль зүйн үндэслэл

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг ямар үндэслэлээр татан буулгах, дуусгавар болгох, асуудал нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Агаарын тухай хууль Цэвэр агаарын сангийн дүрэм зэрэг үндсэн баримт бичгүүдэд нарийвчлан зохицуулагдаагүй байна.

4.1.2.2 Татан буулгах шийдвэр гаргах этгээд

Засгийн газрын тусгай санг татан буулгах шийдвэрийг хэн гаргах нь хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй. Засгийн газрын тусгай санг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэг бүрчлэн тодорхойлон зааж, ийнхүү зааснаар үүсгэн байгуулах эрх зүйн үндэслэл бий болдог.

Энэ агуулгаас үзэхэд санг татан буулгах тохиолдолд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн тухайн татан буулгах санд хамаарах хэсгийг хүчингүй болгох замаар шийдвэрлэх хууль зүйн шаардлага бий болж байна.

4.1.2.3 Татан буулгах эрх зүйн зохицуулалт

⁴⁴ Эрүүгийн хууль 273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

273.1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

273.1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан;

273.1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан;

273.1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

273.1.5. төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан;

273.1.6.улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

273.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Иргэний хуулийн 38 дугаар зүйлд санг татан буулгах ерөнхий журмыг зохицуулсан байна.

Иргэний хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилогдсон татан буулгах комисс эрхлэнэ. Онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болох бөгөөд тэрээр татан буулгах комиссийн гишүүдийн нэгэн адил хариуцлага хүлээнэ” гэж заасан байна.

Улсын Их Хурал нь хуульд өөрчлөлт оруулах бөгөөд харин татан буулгах комиссыг татан буулгах шийдвэр гаргах этгээд томилно гэсэн дээрх Иргэний хуулийн заалтыг баримтлавал Улсын Их Хурал татан буулгах комиссыг томилох хууль зүйн үндэслэл харагдаж байна.

Улсын Их Хурал нь татан буулгах комиссыг байгуулахад татан буулгах комисс Иргэний хуульд заасны дагуу сангийн өдөр тутмын ажил хэргийг зогсоож бэлэн байгаа эд хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж харилцагчтай тооцоо нийлнэ. Ийнхүү тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг татан буулгасан сантай зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй тохиолдолд төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж болохоор Иргэний хуульд зохицуулжээ.⁴⁵

4.1.3 Судалгааны товч дүгнэлт, санал:

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-н 7 дугаар зүйлийн 7.1.1-д “Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх” 7 дугаар зүйлийн 7.1.2-д “Сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хөрөнгийн баталгаа гаргах” 7 дугаар зүйлийн 7.1.3-д “Сангийн үйл ажиллагаатай холбоогүй асуудлаар сангийн хөрөнгөөр хандив өргөх, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, санхүүжүүлэх” гэх Засгийн газрын тусгай сангийн хуульд тодорхойлон заагаагүй зохицуулалтыг оруулжээ. Эдгээр нь тусгай сангийн үйл ажиллагаанд хориглогдож болох бөгөөд ийнхүү нарийвчлан зохицуулалт оруулж болох хэдий ч хариуцлага тооцоход хүндрэлтэй болж байгаа юм.

Эдгээр нь яг тухайлан хуульд заагдаагүй тул Засгийн газрын тусгай сангийн тухай хууль зөрчсөн гэж үзэхэд хүндрэлтэй болж байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа юм. Иймээс Иргэний хуулийн нийтлэг зохицуулалтыг удирдлага болгон шийдвэрлэхээс өөр арга байхгүй болж байна.

Санал:

Засгийн газрын тусгай санг татан буулгах шийдвэрийг хуульд өөрчлөлт оруулах замаар гаргахдаа Улсын Их Хурал ямар үндэслэлүүдийг харгалзан үзэх, татан буулгах комиссыг хаанаас хэрхэн томилох, татан буулгах саналыг хэн гаргаж болох, зэрэг нөхцөл

⁴⁵ Иргэний хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 38.3 дугаар заалт

байдлуудыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулах, эсхүл Цэвэр агаарын сангийн дүрмэнд “Татан буулгах” гэсэн нэг бүлэг нэмж оруулах.

5 Цэвэр агаарын сангийн холбогдох дүрэм журамд хийсэн судалгаа

5.1 Бүлгийн талаар товч танилцуулга

Энэхүү бүлэгт Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй үндсэн дүрэм журмууд болох “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн ажиллах журам”, Цэвэр агаарын сангийн дүрэм, “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам”, Цэвэр агаарын сангийн “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг дүрэм журмуудад эрх зүйн судагаа хийсэн болно.

Судалгаагаар дээрх дүрэм, журмууд батлагдан гарах эрх зүйн үндэслэлийг судалж дүгнэлт өгсөн бөгөөд дүрэм журмын тодорхойгүй, зөрчилтэй, хуульд нийцээгүй, заалт тус бүр дээр тайлбар өгч, гарц болох сөрөг үр дагаврыг тодорхойлон хэрхэн засаж болох талаар төсөл гүйцэтгэгчийн зүгээс судалгаанд оруулсан юм.

Мөн судалгаанд хамрагдсан дүрэм журмуудад нэмж зохицуулах шаардлагатай гэж үзсэн зүйлүүдийг санал болгон оруулсан.

Энэхүү судалгаа нь Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалтын суурь судалгаа бөгөөд энэхүү судалгаанд үндэслэн тус сангийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм журмыг боловсронгуй болгож ажил үргэлжлэн явах болно.

5.2 Засгийн газрын 2010 оны 273 тоот тогтоолоор батлагдсан “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн ажиллах журам”-д хийсэн судалгаа.

5.2.1 Журмыг батлах эрх зүйн үндэслэл

Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална” гэж заасныг үндэслэл болгон Засгийн газар 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 273 тоот тогтоолоор уг журмыг баталсан нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Журмын зүйл, заалтуудад хийсэн судалгаа:

№	Журмын заалт	Тайлбар	Гарч болох сөрөг үр дагавар	Санал
1.	Гишүүдийг зөвлөлийн даргын санал болгосны дагуу Ерөнхий сайд томилж чөлөөлнө. <i>/Журмын 2.3/</i>	Гишүүдэд тавигдах шалгуур, мөн чөлөөлөх хууль зүйн үндэслэл зохицуулагдаагүй	Гишүүдэд шалгуур тавиагүйгээс зөвлөлийн гишүүдийн ажиллах чадвар боломж, мөн мэргэжлийн чиг хандлага харгалзахгүй зөвлөлийн гишүүн болж болохоор байгаа нь удирдах зөвлөлийн шийдвэр, хяналт үр дүнтэй хэрэгжих магадлалыг бууруулна. Мөн зөвлөлийн гишүүнийг	Зөвлөлийн гишүүнд тавигдах шалгуурыг журманд зохицуулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Мэргэжлийн хувьд байгаль орчин, санхүү, хуулийн мэргэжил бүхий чиглэлийн гишүүдийн тоог тус бүр 2 байхаар

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн судалгаа

			чөлөөлөх тодорхой үндэслэл байхгүй байх тул Зөвлөлийн дарга ямар ч үндэслэлээр чөлөөлөх саналыг гаргаж болохоор байна.	хуульчлан зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна. Мөн гишүүнийг чөлөөх үндэслэлийг тодорхой оруулах шаардлагатай.
2.	Байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн нь Цэвэр агаарын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий гүйцэтгэх захирлыг Зөвлөлийн саналыг үндэслэн томилж чөлөөлнө. <i>/Журмын 2.4/</i>	“Цэвэр агаарын сангийн дүрмийн 2.8.2-т “Сангийн гүйцэтгэх захирлыг томилж чөлөөлөх” нь Удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарч байгаа нь зөрчилдөж байна. Мөн гүйцэтгэх захиралд тодорхой шалгуур тавигдаагүй байгаа болно.	“Цэвэр агаарын сангийн дүрэм болон “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмын заалтууд хоорондоо зөрчилдөж байгаа нь гүйцэтгэх захирлыг томилохдоо баримтлах зохицуулалтыг ойлгомжгүй болгож байна. Мөн гүйцэтгэх захиралд ямар нэгэн шалгуур тавиагүйгээс ямар ч туршлага, мэдлэггүй хүн гүйцэтгэх захирлаар томилогдох боломжийг бий болгож байгаа юм.	Гүйцэтгэх захирлын томилох асуудлыг Байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн томилоор заасныг удирдлага болгож дүрмэнд өөрчлөлт оруулж уг заалтыг хасах, Гүйцэтгэх захиралд тодорхой шалгуур тавьж “Цэвэр агаарын сангийн дүрмэнд оруулах.
3.	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмын төсөл болон нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудалд өгөх зөвлөмж <i>/Журмын 3.5.1/</i>	Энэхүү заалт нь “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг батлах эсэх, мөн зөвлөмжийг хэнд хандаж гаргах зэрэг асуудлыг ойлгомжтой зохицуулаагүй байна.	“Цэвэр агаарын сангийн дүрэм, “Цэвэр агаар санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам зэрэг үйл ажиллагааг зохицуулах дүрэм журмыг Байгаль орчин аялал жуулчлалын сайд батлаад байгаа юм. Эдгээр журмуудыг хэн батлах асуудал зохицуулагдаагүй тул зөвхөн удирдах зөвлөлийн дарга батлан гаргах нөхцөл байдал бий болоод байна.	Цэвэр агаарын сантай холбоотой дүрэм журмыг Зөвлөл батлахаар хоёрдмол утга санаагүй заалтыг оруулж өгөх
4.	“Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой асуудлаар иргэн аж, ахуйн нэгж байгууллагаас тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх <i>/Журмын 3.5.7/</i>	Санал хүсэлт гаргасан тухай бүр бүх санал хүсэлтийг шийдвэрлэнэ гэдэг нь хагас жилд нэг удаа хуралддаг удирдах зөвлөлийн хувьд хэрэгжих боломжгүй зохицуулалт болсон байна. Мөн санал хүсэлт гаргасан тохиолдол болгонд хүлээн авч хуралдах эсэх нь тодорхойгүй байна.	Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа удаашрах үр дагавар бий болж байна.	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа болон санхүүгийн асуудалд гаргасан иргэдийн өргөдөл гомдлыг эрх хэмжээний асуудалд хамаарахыг Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Удирдах зөвлөлийн дарга шийдвэрлэж байхаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

5.2.2 Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:

- Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг уг журамд тусгаагүй байна. Мөн Гүйцэтгэх захирлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаа зохицуулагдаагүй байна.
- Журамд гишүүдийн үүрэг хариуцлагын талаарх зохицуулалт байхгүй байна. Өөрөөр хэлбэл гишүүн зөвлөлийн хуралд удаа дараа ирээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авч болох, үүнээс шалтгаалан хурлын ирц удаа дараа бүрдэхгүй бол ямар арга хэмжээ авах зэрэг нөхцөл байдал зохицуулагдаагүй байгаа юм.

5.3 Цэвэр агаарын сангийн дүрэмд хийсэн судалгаа

5.3.1 Дүрэм батлах эрх зүйн үндэслэл

Одоогоор Байгаль орчин, аялал жуучлалын сайд Цэвэр агаарын сангийн дүрмийг батлаад байгаа боловч уг дүрмийг батлах эрх хэмжээг шууд олгосон эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа юм. /Энэ талаар энэхүү судалгааны 2.2.5-д тодорхой тайлбарласан болно./

Дүрмийн зүйл заалтуудад хийсэн судалгаа

№	Дүрмын заалт	Тайлбар	Гарч болох сөрөг үр дагавар	Санал
1.	Сангийн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн батална. /Дүрмийн 2.5/	Энэ заалтыг Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.2-д заасан заалттай нийцүүлэх шаардлагатай.	Цэвэр агаар сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журамд 2.2-д зааснаар орлогч дарга Сангийн дэд сайд байхаар, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан нэгжийн дарга байхаар зохицуулсан байдаг. Гэтэл дүрмэнд эдгээр заалтууд ороогүй байх бөгөөд удирдах зөвлөлийн даргаас бусдыг Ерөнхий сайд томилохоор оруулсан нь зөрчилтэй байгаа юм.	Заалтыг шууд Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.2-д заасны дагуу зохицуулах.
2.	“Удирдах зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана” /Дүрмийн 2.6/	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журамд 3.2-т “Зөвлөл нь хагас жил тутамд нэг удаа хуралдана” гэж заасантай зөрчилдөж байна.	Удирдах зөвлөл хэрэв энэхүү дүрмийн заалтыг баримталвал жилд 1 удаа хуралдахад хангалттай болж байна. Гэтэл засгийн газраас баталсан журамд хагас жил тутамд өөрөөр хэлбэл, дор хаяж 2 удаа хуралдахаар заасан байгаа юм.	Журмын заалттай нийцүүлж өөрчлөлт оруулах шаардлагатай.
3.	Сангийн гүйцэтгэх удирдагыг томилох, чөлөөлөх. Энэ эрхийг удирдах зөвлөлийн эрхэд хамааруулсан байна. /Дүрмийн 2.8.2/	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.4-д заасантай зөрчилдөж байна. Уг заалтад энэхүү гүйцэтгэх захирлыг томилж чөлөөлөх эрхийг Байгаль орчин аялал жуулчлалын сайдад олгосон байна.	Гүйцэтгэх захирлыг ямар этгээд томилох, чөлөөлөх эрхтэй болохыг тодорхойгүй болгож байна.	Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмын заалтыг шууд авч хэрэглэх.
4.	Сангийн үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын тайланг холбогдох засгийн газрын гишүүн болон бусад байгууллагад хүргүүлэх, /Дүрмийн 2.8.9/	“ Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 5.1-д “Байгаль орчны асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн сангийн Удирдах зөвлөлийн саналыг	Энэхүү 2 заалт мөн зөрчилдөж байгаа нь Төсвийн ерөнхийлөн захирагч болон Удирдах зөвлөлийн эрх хэмжээг тодорхойгүй болгож байна.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулинд нийцүүлж төсвийн ерөнхийлөн захирагчид эрх хэмжээг олгох

		тусгах замаар сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг хянан боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд өөрийн багцад оруулан төлөвлөж тайлагнана. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгахаар зохицуулсан байна”		
--	--	---	--	--

5.3.2 Дүрэмд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:

- Тус дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2. “Сангийн хөрөнгийг “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам” болон холбогдох бусад хууль тогтоомжинд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглоно” гэж заасан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл тусгай сангийн хөрөнгийг зөвхөн хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахаас аливаа нэг журмаар зохицуулахгүй.
- Иргэний хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу “Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно”. Харин Цэвэр агаарын сангийн дүрэмд хяналтын байгууллагын асуудал тусгагдаагүй байна. Иймээс Хяналтын зөвлөлийг удирдах зөвлөлөөс томилохоор нэмж тусгах.
- Сангийн дүрэмд сангийн үйл ажиллагааг дуусгавар болгох асуудлыг зохицуулж оруулах шаардлагатай байна.

5.4 “Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д хийсэн судалгаа

5.4.1 Журам батлах эрх зүйн үндэслэл

Одоогоор Байгаль орчин, аялал жуучлалын сайд “ Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ыг батлаад байгаа боловч уг дүрмийг батлах эрх хэмжээг шууд олгосон эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа юм. /Энэ талаар энэхүү судалгааны 2.2.5-д тодорхой тайлбарласан болно./

Журмын зүйл заалтуудад хийсэн судалгаа

№	Журмын заалт	Тайлбар	Гарч болох сөрөг үр дагавар	Санал
1.	Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулах, эрхийг удирдах зөвлөлд олгосон	Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	Ийнхүү удирдах зөвлөлд эрх өгсөнөөр удирдах зөвлөл худалдаж авах бараа үйчилгээний хэмжээ хамаархгүйгээр сонгон	Хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчийн

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн судалгаа

	заалт байна. /Журмын 2.1.2/	тухай хуульд заасан журмын дагуу Худалдан авах бараа, ажил үйлчилгээний хэмжээнээс хамааран захиалагч нь ямар төрийн байгууллага байх талаар зохицуулалт байдаг. Гэтэл уг заалтад ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шууд төсөл хөтөлбөрийг шалгаруулах эрхийг удирдах зөвлөлд өгсөн нь хууль зөрчиж байна.	шалгаруулалт зарлан шалгаруулах эрхтэй болж байгаа юм.	хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Цэвэр агаарын сан захиалагч болох боломжит хэмжээний бараа ажил үйлчилгээг худалдан авах сонгон шалгаруулалтыг удирдах зөвлөл зохион байгуулж болно.
2.	“Хандивлагч орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр”-т сангийн хөрөнгийг арилжааны банкинд байршуулахаар тусгайлан заасан бол тухайн санхүүжилтын хөрөнгийг банкинд оновчтой байршуулж, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрхийг гүйцэтгэх удирдлагад олгосон заалт байна. /Журмын 3.1.5/	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.4.10, 5.4.16-д зааснаас бусад тусгай сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна” гэж заажээ. Тус хуулийн 5.4.10 болон 5.1.16-д Цэвэр агаарын сан хамаархгүй байгаа бөгөөд “Олон улсын гэрээ” гэдэг гадаадын ямар нэгэн байгууллагатай хийсэн гэрээ болгон хамаарахгүй билээ. ⁴⁶	Энэхүү заалтаар гадаадын аль нэг байгууллагатай байгуулсан аливаа хамтран ажиллах гэрээгээр арилжааны банкинд мөнгө байршуулахаар харилцан тохиролцсон агуулга харагдаж байна. Гэвч аливаа нэг байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээ бүр хууль зүйн хувьд “Олон улсын гэрээ” гэсэн ойлголтыг хамаарахгүй.	Энэхүү журмын заалтыг “Олон улсын гэрээ”-ний тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.
3.	Сангийн урсгал зардал, үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг сангийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр гаргах, /журмын 4.2.8/	Энэхүү санхүүжүүлэлт нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заагдаагүй санхүүжилт юм. Иймээс хуулиар тогтоогоогүй асуудлыг журмалсан нь хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байгаа юм.	Энэхүү нөхцөл байдал нь хуулиас давсан журам батлах, түүнийг дагаж мөрдсөнөөр хууль зөрчих үндсийг бий болгож байна.	Журмын энэхүү заалтыг хасаж өөрчлөлт оруулах
4.	Хандивлагч байгууллага олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээрт зориулалтыг нь тусгайлан заасан тохиолдолд зориулалтын дагуу ашиглах /Журмын 4.2.9/	Энэ заалт нь мөн хуулиар заагдаагүй санхүүжүүлэх хэлбэр болж байгаа юм.	Энэхүү нөхцөл байдал нь хуулиас давсан журам батлах, түүнийг дагаж мөрдсөнөөр хууль зөрчих үндсийг бий болгож байна.	Журмын энэхүү заалтыг хасаж өөрчлөлт оруулах

5.4.2 Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:

- Журмын 7 дугаар зүйлийн 7.1 –д Сангийн явуулахыг хориглосон үйл ажиллагаануудыг дурьдсан байх бөгөөд 7 дугаар зүйлийн 1.1-д “Хуульд заагдаагүй Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага аж ахуйн нэгж иргэдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх”, мөн зүйлийн 7 дугаар зүйлийн 7.1.2-д Сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, бусад байгууллага аж ахуйн нэгж иргэдэд хөрөнгийн баталгаа гаргах” гэсэн заалтуудыг оруулсан байна. Эдгээр заалтууд нь хуульд зохицуулагдаагүй байгаа юм. Ийнхүү хуулиар

⁴⁶ Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д ““Олон улсын гэрээ” гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ”

зохицуулагдаагүй асуудлыг журамласнаар энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй болж байгаа юм.

Санал: Иймд журмын хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

5.5 Цэвэр агаарын сангийн “Хөдөлмөрийн дотоод журам”- д хийсэн судалгаа

5.5.1 Журмыг батлах эрх зүйн үндэслэл

Хөдөлмөрийн дотоод журмыг Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлын 2011 оын 06 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тушаалаар баталжээ.

Гүйцэтгэх захирал нь энэхүү журмыг батлах эрхтэй эсэх нөхцөл байдал мөн тодорхойгүй юм.

“ Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.1-д “Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмын төсөл болон нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудалд өгөх зөвлөмж” гэж удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудалд оруулан зааснаас үзэхэд уг журмыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлах ёстой байсан байна.

Гэтэл уг журмыг баталсан Гүйцэтгэх захирлын тушаалын үндэслэлд удирдах зөвлөлийн шийдвэр гэж ороогүй байх бөгөөд харин Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 130 дугаар зүйлүүдийг үндэслэл болгожээ. Үүнээс үзэхэд уг журмыг удирдах зөвлөл хэлэлцээгүй гэж дүгнэх үндэслэлтэй байгаа юм.

Тушаалын үндэслэл хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 130 дугаар зүйлийг бүхэлд нь үндэслэсэн нь буруу байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйл ажил олгогчийн эрх, үүргийг заасан байдаг бөгөөд уг заалтанд Хөдөлмөрийн дотоод журам гаргах ямар нэгэн зохицуулалт байхгүй тул уг зүйлийг үндэслэх нь тохиромжгүй. Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1. “Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ” гэж заасныг үндэслэл болгож болох боловч уг зүйлийг бүхэлд нь үндэслэх нь мөн тохиромжтой биш байгаа юм.

Учир нь Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлд 130.3 –д “Төрийн зохих байгууллагаас сахилгын тусгай дүрэм батлан мөрдүүлж болно.” гэсэн заалт байдаг бөгөөд энэхүү заалт нь Хөдөлмөрийн дотоод журам боловсруулах үндэслэл болсон заалт биш юм.

Журмын зүйл заалтуудад хийсэн судалгаа:

№	Журмын заалт	Тайлбар	Гарч болох сөрөг үр дагавар	Санал
1.	Цагдаагын ерөнхий газраас тодорхойлолт /Журмын 1.1.7/	Цагдаагын Ерөнхий газраас ямар тодорхойлолт авах нь тодорхойгүй байна.	Ажилт орохыг хүсэгчид ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг бий болгож байна.	Цагдаагын ерөнхий газраас ял шийтгэлтэй эсэх талаарх тодорхойлолт гэж тодруулж оруулах

Цэвэр агаарын сангийн хууль тогтоомжийн судалгаа

2.	Ажилд албан тушаалд томилох, ажлаас чөлөөлөх /нэгдүгээр зүйл/	Ажлаас чөлөөлөх, халах гэсэн ойлголт нь буруу, учир нь ажлаас халах гэдэг нь сахилгын шийтгэлийн нэг хэлбэр юм.	Энэхүү зохицуулалтаар зөвхөн ажлаас халах гэсэн сахилгын шийтгэлийн хэлбэрийг зохицуулахаар ойлгогдож байна. Гэтэл ажилтан өөрийн саналаар хөдөлмөрийн гэрээг цуцлах, тэтгэвэрт гарах зэрэг хөдөлмөрийн харилцааг харилцаа дуусгавар болгох, үндэслэлүүдийг хууль зүйн хувьд орхигдуулсан заалт болжээ.	Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох гэж өөрчлөх.
3.	Шинээр орж байгаа ажилтанд туршилтын болон сургалтын хугацаа олгохгүй /Журмын 1.3/	Энэ заалтын агуулга нь ойлгомжгүй байна. Туршилт гэдэг нь хөдөлмөрийн харилцаанд тухайн ажилтан ажлаа цаашид үр бүтээлтэй үргэлжлүүлж чадах эсэхийг тогтооход зориулсан хугацаа. Харин сургалт гэдэг нь туршилтад үл хамаарах ажилтан мэргэшихэд чиглэсэн хугацаа болно.	Энэхүү заалтаар туршилтын хугацаа олгохыг шууд хориглосон заалт байна. Туршилтын хугацаа нь ажилтныг тодорхой хугацаанд ажиллуулж ажилтны хувийн болон, ур чадварыг тогтооход зориулагдсан хугацаа бөгөөд энэ нь боловсон хүчний бодлогын хувьд хэрэгтэй зүйл юм. Харин сургалтын хугацаа олгохгүй гэсэн ажилтны сурч боловсрох эрхийг хязгаарласан зохицуулалт байна.	Туршилтын хугацааг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд олгож байхаар зохицуулах, мөн сургалтын гэснийг хасах
4.	Зайлшгүй шаардлагын улмаас ажил үүргийн хуваариас өөр ажил гүйцэтгүүлэх, эсхүл албан тушаал хавсруулан ажиллуулж болно. /Журмын 1.5/	Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн байна. “Өөр ажил гүйцэтгүүлэх” гэсэн ойлголт хөдөлмөрийн харилцаанд байхгүй. Харин “өөр ажилд шилжүүлэх” гэсэн ойлголт байдаг бөгөөд үнийг Хөдөлмөрийн тухай хуулийн 26.1-д дараах байдлаар заасан байдаг: “Ажилтан ажлын цагтаа багтаан өөрийн буюу бусад байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх, өөрийн байгууллагад өөр ажил хослон гүйцэтгэх болон ажил олгогч ажилтантай тохиролцсоноор эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх буюу түүний ажлын ачааллыг нэмэгдүүлэн ажиллуулж болно”.	Хөдөлмөрийн дотоод журам нь Хөдөлмөрийн хуулинд нийцсэн байх шаардлагатай. Уг заалтаар ажил олгогч нь шаардлагатай гэж үзвэл ажилтнаар ямар ч ажил хийлгэж болохоор байх бөгөөд мөн хуульд заасан үндэслэлээс гадуур ажил албан тушаал хавсруулан гүйцэтгүүлэх үндэслэл болж байна.	Хөдөлмөрийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.
5.	Ажилтныг ажлаас чөлөөлөх, халахад Хөдөлмөрийн хуулийн 39.40 дүгээр зүйлд заасан үндэслэлийг баримтлахаас гадна дараах тохиолдлуудад ажлаас шууд хална. /Журмын 1.6/	Хөдөлмөрийн хуулийн 39 дүгээр зүйл нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах заалт юм. Иймээс үүнийг ажлаас халах зохицуулалттай хамт зохицуулах шаардлаггүй.	Журамд ийнхүү хамт зохицуулсанаар ажилтан өөрийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах зохицуулалт ажлаас шууд халах зохицуулалттай хамт орж байна.	Тус тусад зохицуулалтыг салгаж журамд оруулах.
6.	Хоёр удаа сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд 3 дахь удаагаа сахилгын шийтгэл хүлээх нөхцөл бүрдсэн тохиолдолд ажлаас халахаар заажээ. /Журмын 1.6.1/	Сахилгын шийтгэлийн хөөн хэлэлцэх хугацаа гэж байдаг бөгөөд Хөдөлмөрийн хуулийн Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4. “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил	Энэхүү заалтаар сахилгын шийтгэл хүлээсэн бол хичнээн хугацаа өнгөрсөн ч 3 дахь удаагаа сахилгын шийтгэл оноох нөхцөл бүрдсэн тохиолдолд ажлаас халагдах нөхцөл	Хөдөлмөрийн хуулийн 131 Дүгээр зүйлийн 131.4 заасанд нийцүүлэх

	өнгөрвөл шийтгэлгүйд заасан байдаг.	сахилгын тооцно” гэж	байдал бий болгож байна.	
--	-------------------------------------	----------------------	--------------------------	--

5.5.2 Журамд нэмж тусгавал зохих зүйлийн талаар:

- Хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт. Үүнд:

/Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын эрх үүрэг зэргийг тодорхой оруулан үүнд гүйцэтгэх захирал нь ажилчидтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээг цуцлах, сахилгын шийтгэл оногдуулах эрх хэмжээг тусгаж өгөх тодорхой журамлан оруулах/

- Байгууллагын дотоод үйл ажиллагаа. Үүнд:

/Байгууллагын бичиг хэрэг хөтлөх, архивлах, бичиг хэргийг хянах, тамга тэмдэг ашиглах журам зэргийг тусгах/

- Захиргаа ба ажилтны эрх, үүрэг. Үүнд:

/Ажил олгогч эрх үүрэг, ажилтны эрх үүргийг тодорхой тусгах/

- Эд хөрөнгийн хариуцлага. Үүнд:

/Байгууллагын эд хөрөнгөтэй хэрхэн харьцах, байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаарх нарийвчилсан зохицуулалт тусгах/

- Дотоод хяналт шалгалт гэх мэт асуудлуудыг оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

/Байгууллагын ажилчдад дотоод хяналтыг хэрэгжүүлэх арга механизмыг тусгах шаардлагатай/

СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ:

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг дараахь хууль, эрх зүйн актуудаар зохицуулж байна. Үүнд:

ХУУЛЬ:

- 1 Монгол Улсын Үндсэн хууль
- 2 Агаарын тухай
- 3 Агаарын бохирдлын төлбөрийн тухай
- 4 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль
- 5 ЗГ-ын тусгай сангийн тухай
- 6 Иргэний хууль
- 7 Төрийн болон орон нутгийн өмчийн Хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- 8 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
- 9 Төрийн нууцын тухай
- 10 Хувь хүний нууцын тухай
- 11 Байгууллагын нууцын тухай
- 12 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
- 13 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- 14 Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
- 15 Нягтлан бодох бүртгэлийн тухай
- 16 Газрын тухай
- 17 Төрийн албаны тухай
- 18 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
- 19 Төрийн хяналт, шалгалтын тухай
- 20 Төрийн аудитын тухай
- 21 Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай
- 22 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай
- 23 Татварын ерөнхий хууль
- 24 Хөдөлмөрийн хууль

УИХ-ЫН ТОГТООЛ:

- 1 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2011 оны 11 дүгээр тогтоол.
- 2 “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2010 оны 36 дугаар тогтоол.
- 3 Төрөөс экологийн талаар баримтлах бодлого батлах тухай 1997 оны 106 дугаар тогтоол.
- 4 Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2007 оны 46 дугаар тогтоол.

ЗГ-ЫН ТОГТООЛ:

1. Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай 2008 оны 14 дүгээр тогтоол.
2. Нийслэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2007 оны 70 дугаар тогтоол.
3. Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр батлах тухай 2005 оны 245 дугаар тогтоол.
4. Утаа багатай түлш, хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай 2001 оны 70 дугаар тогтоол.
5. Хөтөлбөр батлах тухай /Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр/ 1999 оны 25 дугаар тогтоол.
6. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай / Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр / 2002 оны 182 дугаар тогтоол.
7. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай /Агаарыг хамгаалах хөтөлбөр/ 1999 оны 82 дугаар тогтоол.
8. Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай 2002 оны 140 дүгээр тогтоол.
9. Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам. 1999 оны 104 дүгээр тогтоол.
10. Хөтөлбөр батлах тухай /Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр 1999 оны 50 дугаар тогтоол.
11. Үндэсний хөтөлбөр батлах тухай /Озоны үе давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөр 1999 оны 129 дүгээр тогтоол.
12. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам. 2010 оны 273 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
13. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам. 2011 оны тогтоолын 1 дүгээр хавсралт.
14. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам. 2011 оны дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

БОАЖ-ЫН САЙДЫН ТУШААЛ

1. Журам батлах тухай / Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны дүрэм, Агаарын чанарын мэдээлэл гаргах журам, Иргэн,аж ахуйн нэгж,байгууллагын суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээ тогтоох төсөл боловсруулах журам, Агаарыг бохирдуулах эх үүсвэрийн улсын тоо бүртгэл явуулах журам, Иргэн,аж ахуйн нэгж,байгууллагын суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодис гаргах зөвшөөрөл олгох журам/ 1996 он. Дугаар 98
2. Заавар батлах тухай /Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөх аргачилсан заавар, Химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулах аргачилсан заавар/ 2000 он. Дугаар 45
3. Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам. 2011. А-200 тоот тушаал. 4 дүгээр хавсралт
4. Цэвэр агаарын сангийн дүрэм. 2011 оны А-200 тоот тушаал. 1 дүгээр хавсралт.
5. Цэвэр агаарын сангийн стратеги, бүтэц зохион байгуулалтын хөтөлбөр. 2011 оны А-200 тоот тушаал. 2 дугаар хавсралт.

6. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааны төсөв, урсгал зардал. 2011 оны А-200 тоот тушаал. 3 дугаар хавсралт.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1. Жагсаалт, журам батлах тухай /Химийн бодисын хаягдлыг байгаль орчинд халгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах технологийн аргачилсан заавар, Аюултай, хортой химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, тээвэрлэх, ашиглах, үйл ажиллагааг зохицуулах журам /2003 он. Дугаар 126/171

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 1 дүгээр хавсралт.
2. Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 2 дугаар хавсралт.
3. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 3 дугаар хавсралт.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1. Хязгаарлалтын бүс тогтоохтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай. 2011 оны 351 тоот захирамж.

ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2. Хөдөлмөрийн дотоод журам. 2011 оны 7 дугаар тушаал.